



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль

Хөтөлбөрийн нэр: Сувилахуй

Индекс: 091301 бакалавр

Шинжээчийн баг:

Ахлагч:	С.Сэргэлэнчимэг	Энэрэл дээд сургуулийн ахлах багш, клиникийн профессор, анагаахын шинжлэх ухааны магистр
Гишүүд:	Ц.Амаржаргал	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Сувилахуйн албаны дарга, сувилахуйн ухааны магистр, сувилахуйн Зөвлөх зэрэгтэй
	Г.Шүрэнмягмар	Этүгэн их сургуулийн Сувилахуйн сургуулийн сувилахуйн тэнхимийн ахлах багш, сувилахуйн ухааны магистр
	Ц.Оюундарь	Олон Улсын Улаанбаатарын Их Сургуулийн Сувилахуйн сургуулийн дэд профессор, доктор

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

Товчилсон үгийн тайлбар

АШУҮИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
АУС	Анагаах Ухааны Сургууль
УНТЭ	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг
ИС	Их сургууль
ОУУБИС	Олон улсын Улаанбаатар Их сургууль
СС	Сувилахуйн сургууль
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БШУ	Боловсрол шинжлэх ухаан
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
МУ	Монгол улс

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар анагаах ухааны сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Сувилахуй	
Индекс	091301 бакалавр	
Шинжээчид	<p>Ахлагч: С. Сэргэлэнчимэг, Энэрэл дээд сургуулийн багш, АШУ-ы магистр, клиникийн профессор</p> <p>Гишүүд: Ц. Амаржаргал УНТЭ-ийн Сувилахуйн албаны дарга Г. Шүрэнмягмар Этүгэн ИС-ийн СС-ийн багш Ц.Оюундарь ОУУБИС-ийн СС-ийн ахлах багш</p>	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Н.Түмэнжаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2023.06.12	Сургуулийн орчинтой танилцах
		Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцах
		Оюутнуудын төлөөлөлтэй уулзах
		Төгсөгчдийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/
	2029.06.13	Ажил олгогчийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/
		Багш нартай уулзах
		Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.		
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургууль нь Сувилахуйн мэргэжлээр бакалаврын сургалтын хөтөлбөрийг 1998 оноос хэрэгжүүлж эхэлснээр 24 дэх жилдээ сургалт явуулж, 1000 гаруй бакалавр зэрэгтэй сувилагч бэлтгэж, төвийн болон хойд бүсийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийг тасралтгүй хангаж ирсэн байна.

Мэргэжилтний цогц чадамж нь Эрүүл мэндийн сайдын 2012 оны А/102 тоот тушаалаар батлагдсан сувилагч мэргэжлээр төгсөгчдөд тавигддаг, ажил олгогчдын чухалчилдаг, нэн шаардлагатай чадваруудтай нийцдэг.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн 5 тэнхимийн 29 багш оролцдог бөгөөд 28,8 % нь доктор, 4,8% нь дэд профссор, 40,2 % нь ахлах багш, 38,1% нь багш, 17,4% нь дадлагажигч багшийн албан тушаалд ажилладаг.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны сургууль нь үнэмлэхтэй сувилагчаас дээд боловсролтой бакалавр, дипломын хөтөлбөрөөр 5469 сувилагч бэлтгэсэн нь сургуулийн нийт төгсөгчдийн 51,4 хувийг эзэлж байна.
- Сувилахуйн бакалаврын сургалтыг 1998 оноос эрхэлж 25 жилийн хугацаанд 982 бакалаврын боловсролтой сувилагч мэргэжилтэнг бэлдсэн.
- Сувилахуйн чиглэлээр хамтын ажиллагаатай Японы Жичи АУС-ийн Сувилахуйн сургуулийн сувилахуйн хөтөлбөр, БНСУ-ын Ионсейн их сургуулийн Сувилахуйн сургуулийн сувилахуйн хөтөлбөр, Этүгэн их сургууль сувилахуйн хөтөлбөрийг судалсан.
- 2012 онд МУ-ын дээд боловсрол, Сувилахуй MNS:5323-1295:2012 стандартыг баримтлан сургалтын төлөвлөгөө, 2014 онд БШУ-ны сайдын “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага” А/174 тоот тушаалын дагуу сувилахуйн хөтөлбөр шинэчилсэн.

Онцлог зүйл:

- АШУҮИС-ийн Хөгжлийн бодлого, АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө-2030 бодлогын баримт бичгийн хүрээнд сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөх, хэрэгжүүлэн зохион байгуулах, үнэлэх, тасралтгүй сайжруулахын тулд 2017 оноос чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг, 2018 оноос суралцагчдад байгальд ээлтэй хандлага төлөвшүүлж, сургалтын ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015 стандартыг тус тус хэрэгжүүлж байгаа.
- Сувилахуйн бакалаврын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, шинэчлэх, хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүй болон чанарын удирдлагаар ханган, үр дүнг тооцож, сургалтын хөтөлбөрийг дотоодын, олон улсын хөндлөнгийн байгууллагаар магадлан итгэмжлүүлэх, бэлтгэл ажлыг хангах зорилгоор сургуулийн удирдлага, эрдэмтэд, тэнхим, багш, ажил олгогчид, төгсөгчдийн төлөөлөл 15 хүний бүрэлдэхүүнтэй Хөтөлбөрийн дэд хороо 2017 онд байгуулагдан үйл ажиллагаагаа тогтмол явуулж байгаа.
- Ажил олгогчдын уулзалтыг жил бүр зохион байгуулж байна.
- Төгсөгчид, ажил олгогчид, суралцагсдаас “Сэтгэл ханамжийн судалгаа” авч судалгааны үр дүнд тулгуурлан эмнэлзүйн орчинд дадлага сургалтыг зохион байгуулах, төрөлжсөн сувилахуйн заах арга зүйг сайжруулах ажлыг хийж байна.

Дүгнэлт:

АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар АУС-ийн Сувилахуйн бакалаврын сургалтын хөтөлбөр нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын IV зорилт Чанартай боловсрол, ДЭМБ-ын Сувилахуйн болон Эх барихуйн тусламж үйлчилгээний стратеги 2021-2025, Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого – Алсын хараа 2050, Төрөөс Боловсролын болон Эрүүл мэндийн талаар 2024 он хүртэл баримтлах бодлого, Монгол Улсын Дээд боловсролын стандарт, Сувилахуй MNS5323-129:2012, Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын 2014 оны А/174 дугаартай тушаал зэрэг бодлогын баримт бичгүүдийг баримтлан боловсруулсан байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Монгол Улсын боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, Боловсролын тухай болон Дээд боловсролын тухай хууль, АШУҮИС-ийн хөгжлийн бодлого, АШУҮИС-ийн эрхэм зорилго, алсын хараа, АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль хөгжүүлэх стратеги төлөвлөгөө 2030, Сувилахуйн салбарын хөгжлийн чиг хандлага, хүний нөөцөд тавигдах шаардлага зэргийг үндэслэн хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилго, зорилтоо тодорхойлсон.
- АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн алсын хараа, эрхэм зорилгын дагуу хөтөлбөрийн хүрэх үр дүн /PLO/-г /1/ үйлчлүүлэгч төвтэй тусламж үзүүлэгч, /2/ мэргэжилтэн, /3/ мэдээлэл зүйч, технологич, /4/ нотолгоонд суурилсан тусламж үзүүлэгч, /5/ манлайлагч, /6/ тогтолцоонд түшиглэсэн тусламж үзүүлэгч, /7/

аюулгүй байдлыг хангагч, /8/ харилцагч, /9/ багаар ажиллагч, хамтрагч, /10/ чанарыг сайжруулагч 10 чадамжтай, 63 төрлийн мэдлэг, 174 ур чадвар, 62 хандлагын үзүүлэлтээр тодорхойлон хэрэгжүүлсэн.

- Хөтөлбөрийн зорилгоо “үйллүүлэгчид сувилахуйн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлдэг, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг дээдлэн ажилладаг, өөрийн ажилдаа шинэ технологийг ашигладаг, нотолгоотой судалгаанд суурилсан тусламжийг аюулгүй байдлаар үзүүлдэг, мэргэжил нэгт нөхдөө манлайлагч, багаар хамтран ажиллах чадвар бүхий цогц чадамжтай мэргэжилтэн бэлтгэхэд оршино хэмээн тодорхойлсон.
- АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль нь 1998 оноос сувилахуйн мэргэжлээр сувилахуйн арга зүйч буюу бакалаврын сургалтыг эхлүүлж зорилго зорилтуудыг нийгмийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчдын хэрэгцээнд тулуурлан, дүрэм журамтай уялдуулан сайжруулж 2012 онд МУ-ын дээд боловсрол, Сувилахуй MNS 5323-1295:2012 стандартыг баримтлан сургалтын төлөвлөгөө, 2014 онд БШУ-ны сайдын “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага” А/174 тоот тушаалын дагуу сувилахуйн мэргэжилтний цогц чадамжид суурилсан хөтөлбөрийг боловсруулан шинэчилсэн.
- БШУ-ны сайдын 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу сувилагч мэргэжилтний хөтөлбөрийг боловсруулж, төгсөгчдийн хүрэх үр дүн мэргэжилтний цогц чадамжийг тусгасан нь Эрүүл мэндийн сайдын 2012 оны А/102 тоот тушаалаар батлагдсан сувилагч мэргэжлээр төгсөгчдөд тавигдах ажил олгогчдын чухалчилдаг болон ирээдүйд нэн шаардлагатай ур чадваруудыг бүрэн хангаж байна.
- Цогц чадамжинд суурилсан сургалтын хөтөлбөрөөр үйлчлүүлэгчийн хувь хүний хэрэгцээ, үнэ цэн, нас, гарал үүсэл, шашин шүтлэг, аюулгүй байдалд чин сэтгэлээсээ хандан, нэгдмэл байдлаар үр дүнтэй сувилахуйн тусламж үзүүлэгч бэлтгэх зорилготой.

Онцлог зүйл:

- Дэлхийн жишигт нийцсэн чадварлаг мэргэжилтэн бэлтгэх алсын хараа, эрхэм зорилгын хүрээнд, МУ-ын нийгэм эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, олон улсын чиг хандлага, эрүүл мэндийн салбарын эрэлт хэрэгцээнд тулгуурлан 2010, 2014, 2016 онуудад сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан.
- Сувилагч мэргэжлээр төгсөгчдөд тавигдах, ажил олгогчдын чухалчилдаг, нэн шаардлагатай чадваруудтай нийцдэг мэргэжилтний цогц чадамжийг тусгасан сувилахуйн бакалаврын хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагаа явуулж 2020, 2021, 2022 онд 204 бакалавр сувилагч төгссөн.

Дүгнэлт: АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар АУС-ийн Сувилахуйн бакалаврын сургалтын хөтөлбөрийн зорилго нь Монгол улсын боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, Боловсролын тухай болон Дээд боловсролын тухай хууль, АШУҮИС-ийн хөгжлийн бодлого, АШУҮИС-ийн эрхэм зорилго, алсын хараа, АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль хөгжүүлэх стратеги төлөвлөгөө 2030, Сувилахуйн салбарын хөгжлийн чиг хандлага, хүний нөөцөд тавигдах хэрэгцээ шаардлагад нийцсэн байна

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж: Төрөлжсөн сувилахуйн тусламж үйлчилгээ

- Сувилахуйн тусламж үйлчилгээг эмнэлгээс гарч буй өвчтөнд үзүүлж чадаж байгаа эсэхийг судалж үнэлэх
- Ажил олгогчдын уулзалтаас сувилахуйн бакалаврын хөтөлбөрт дараах саналуудыг тусгасан
 - Цахим хэрэглээний чадварыг сайжруулах
 - Төгсөгчдийн Монгол хэл бичгийн мэдлэг, чадварыг сайжруулах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн захирлын 2016 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр баталсан сувилахуйн бакалаврын сургалтын төлөвлөгөө нь 73 чиглэлийн 130 багц цагийн багтаамжтай ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлүүдээс бүрдсэн.
- Сургалтын төлөвлөгөөний дагуу суралцахуйн үр дүнг хичээл бүрээр эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг тусгаж, хичээл хоорондын холбоог хангасан заавал судлах 53, сонгон судлах 20 хичээл, танилцах, ерөнхий сувилахуй, төрөлжсөн сувилахуй, төгсөлтийн өмнөх дадлагын 4 хичээлийн хөтөлбөрийг БШУ-ны сайдын 174 тоот тушаалын дагуу боловсруулж хэрэгжүүлсэн.
- Сувилахуйн бакалаврын хөтөлбөрөөр суралцахуйн үр дүн буюу мэргэжилтний цогц чадамжийг АШУҮИС-ийн хэмжээнд 2016 онд боловсруулсан бөгөөд сувилахуйн бакалаврын хөтөлбөрөөр төгсөгч нь суралцах хугацаандаа мэргэжлийн чиглэлээр 63 мэдлэг, 174 ур чадвар эзэмшиж, 62 хандлагад төлөвшиж, эмнэлзүйн ур чадварыг /Miller.s Pyramid 1990/ 5 түвшинд эзэмшихээр тусгагдсан.
- Мэргэжилтний цогц чадамжийг тодорхойлсон нь Эрүүл Мэндийн Сайдын 2012 оны А/102 тоот тушаалаар батлагдсан сувилагч мэргэжлийн төгсөгчдөд тавигдах ажил олгогчдын чухалчилдаг, нэн шаардлагатай чадваруудтай нийцсэн.
- Хичээлийн хөтөлбөрүүдийг БШУ-ны сайдын А/174 тоот тушаалын дагуу багш бүр боловсруулж, шалгах хуудсаар үнэлэн, тэнхим болон сургуулийн хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцүүлж баталгаажуулсан байна.
- Хөтөлбөрийн үр дүнд (PLO) суурилан, хичээлийн (CLO) суралцахуйн үр дүнгийн төлөвлөлтийг боловсруулахдаа хичээлийн агуулгын, хүрэх үр дүнгийн, хөндлөн болон босоо залгамж холбоонд хамаарлын матрицыг боловсруулан уялдаа холбоог хянан сайжруулснаар тухайн хичээлийн судлах дамжаа, улирал, хичээлийн хуваарь, анги танхим, багшийн сонголт зэргийг нарийвчлан төлөвлөж зохион байгуулдаг байна.
- Сургалтын хөтөлбөрийн үр дүн (PLO), хичээлийн хөтөлбөрийн үр дүн (CLO)-г олгоход (1) Оюутнуудыг асуудал шийдвэрлэх болон бодож сэтгэх ажилд шууд оролцуулах, (2) Оюутнуудад юуг яаж сурахаа ойлгож мэдэхэд туслах, (3) Оюутнуудын сурах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, (4) Оюутнуудад насан туршдаа суралцах дадал зуршлыг бий болгоход туслах гэсэн суралцагсдын оролцоонд

суурилсан идэвхтэй сургалтын нийтлэг зарчмыг багш бүр баримтлан хичээл үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Онцлог зүйл:

- Нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан, цаг үеийн хэрэгцээнд үндэслэж тогтмол сайжруулалт хийдэг.
- 2017 онд сургуулийн удирдлага, эрдэмтэд, тэнхим, багш, ажил олгогчид, төгсөгчдийн төлөөлөл 15 хүний бүрэлдэхүүнтэй хөтөлбөрийн дэд хороо байгуулагдсан. Сувилахуй бакалаврын хөтөлбөр нь дэд хорооны протокол, БШУ-ны сайдын тушаал, АШУҮИС-ийн Захирлын тушаал, хичээлийн хөтөлбөр, хичээлийн төлөвлөгөөн дээр тулгуурлан үйл ажиллагаагаа зохион байгуулдаг.

Дүгнэлт: Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүд нь тухай хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулалт хийсэн байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- 2017, 2018, 2019, 2020, 2021 онуудад хийгдсэн “Төгсөгчдийн мөшгөх судалгаа I, II” /БШУЯ, IRIM судалгааны хүрээлэн “Сургалтын үйл ажиллагаа ба хөдөлмөрийн зах зээлийн судалгаа” УБ 2017/
- АШУҮИС-ийн Захирлын 2016 оны тушаалаар батлагдсан Сувилахуйн сургалтын төлөвлөгөө 73 чиглэлийн 130 багц цагийн багтаамжтай.
- Сувилахуйн мэргэшүүлэх хичээлүүдийн багтаамжийг 2014 оныхоос 2016 онд 24,9 хувиар нэмэгдүүлж хөтөлбөрийн үр дүнг дэмжин ур чадвар эзэмшүүлэхэд чилүүлсэн.
- Гадаад дотоодын магадлан итгэмжлэгдсэн их дээд сургууль төгссөн, шилжин суралцагсдын багц цагийг АШУҮИС-ийн Захирлын 2016 оны А/132 тоот тушаалаар батлагдсан “Багц цаг дүйцүүлэн тооцох журам”-ын дагуу дүйцүүлэн тооцдог.
- Сувилахуйн бакалаврын хөтөлбөрийн дипломын хөтөлбөрөөс ялгарах онцлог нь сувिलाхуйн судалгаа хийх, манлайлах, сэтгэн бодож шийдвэр гаргах арга зүйн мэдлэг, ур чадвар олгож, хандлага эзэмшүүлэх 21 багц цагийн 12 төрлийн хичээлүүдийг нэмэлтээр судлуулдаг.
- Их сургуулийн Удирдлага мэдээллийн системийн тусламжтайгаар суралцагч тухайн улиралд судлах хичээл, хичээл заах багш, хичээлд хамрагдах өдөр, хичээллэх цагаа сонгон суралцах нөхцөл бүрдсэн.

- Хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш улирал бүр оюутнаас үр дүнгийн судалгаа авч тухайн жилийн амжилт, чанарыг өмнөх жилийнхтэй харьцуулан сайжруулалтыг хийдэг.
- Хөтөлбөрийн үр дүнд суурилан, хичээлийн суралцахуйн үр дүнгийн төлөвлөлтийг хичээлийн агуулгын, хөндлөн болон босоо залгамж холбоонд хамаарлын матрицыг боловсруулан уялдааг сайжруулснаар тухайн хичээлийн судлах дамжаа, улирал, хичээлийн хуваарь, анги танхимыг төлөвлөн зохион байгуулдаг байна.
- Сувилахуйн бакалаврын хөтөлбөрөөр суралцагч нь суралцах хугацаандаа 20 чиглэлийн 40 багц цагийн хичээлүүдээс 4 төрлийн 8 багц цагийн хичээлүүдийг сонгон суралцдаг.

Онцлог зүйл:

- Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулах явцад багш суралцагч, ажилтан ажиллагсад хамтран ажиллаж, ур чадварын хувьд хөгжиж байна.
- Сургалтын агуулга, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн нийцлийг хангахын тулд мэргэжлийн болон хичээлийн хөтөлбөрийг оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг үндэслэн тогтмол сайжруулж, хөтөлбөрийн дэд хороогоор хөтөлбөрийн агуулгыг шинэчлэн батлуулсан.
- Оюутны ачааллыг удирдлага мэдээллийн системээс өдрөөр, 7 хоног, сараар гаргаж харж хянадаг.
- Дадлага хийх 13 байгууллагатай гэрээ байгуулан ажилладаг, үйлдвэрлэлийн дадлагыг зохион байгуулах арга зүй удирдамж дамжаа бүрээр гарч, тайлан хамгаалдаг
- Сувилахуйн ангийн оюутнууд 2-р дамжаанаасаа “Нэг сувилагч – нэг оюутан” хөтөлбөрт хамрагдан “Цагаан малгайн ёслол” хийж, Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч, Сургуулийн захиралын хамтарсан тушаалаар шавилан сургалт буюу эмнэлэгт ажиллах оюутны нэрс, чиглүүлэн ажиллах сувилагч нарыг томилж эмнэлзүйн орчинд дадлагажих үйл ажиллагааг явуулж, ур чадварыг нь тэнхимийн багш нарын хамт үнэлдэг

Анхаарах асуудал:

- Суралцагч багшийг сонгох боломж хангалтгүй.

Дүгнэлт:

- АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь АУС-ийн Сувилахуйн бакалаврын сургалтын хөтөлбөрийн сургалтын агуулга нь онол, практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаа холбоотой боловсруулагдсан 20,8% нь ерөнхий суурь, 25% нь мэргэжлийн суурь, 54,2% нь мэргэшүүлэх, 73 чиглэлийн 130 багц цагийн хичээлээр сувилагч мэргэжилтний зайлшгүй эзэмших мэргэжлийн чиглэлийн 63 мэдлэг, 174 ур чадвар, 62 хандлагыг төлөвшүүлэх цогц чадамжийг олгоход чиглэсэн байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- УМС-ийн тусламжтай суралцагч тухай улиралд судлах хичээл, заах багш, хичээлд хамрагдах өдөр, хичээллэх цагаа сонгон суралцах боломж бүрдсэн ч хөтөлбөрөөр элсэгчдийн тооноос хамаараад багшийг сонгох боломж хангалтгүй байгаад дүгнэлт хийх

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо

- Уламжлалт арга зүйгээс - Үр дүнд суурилсан арга зүй, Өвчин суурьтай сургалтаас – Сувилахуй суурьтай сургалт руу шилжсэн.
- Монгол улсын стандартаас - Олон улсын стандарт руу чиглэсэн
- Сургалтын SPICES-T загвар/ зайлшгүй эзэмших мэдлэг, чадвар, хандлага, дадлыг бий болгоход чиглэгдсэн арга зүйгээр зохион байгуулж байна.
- 1-2 дугаар дамжаанд онолын хичээлүүд давамгайлж онол, дадлага, семинарийн хэлбэрээр, 3 дугаар дамжаанаас мэргэжлийн суурь, төрөлжсөн сувилахуйн хичээлүүдийг эмнэлзүйд суурилсан арга барилыг ашиглан зааж байна.
- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “АШУҮИС-ийн сургалтын технологи, чанарын хяналтын журам”-ын 3 дугаар бүлэг “Сургалтын арга хэлбэр”-т тусгасан лекцийн хичээл, дадлага, семинар, бие даалтын хичээлийн технологийг сургалтад хэрэгжүүлж, хичээл хөтлөн явуулах замын зургийг мөрддөг байна.
- Төрөлжсөн сувилахуйн хичээлүүдийг сувилахуйн ур чадвар, гардан үйлдлийг оюутан богино хугацаанд зөв оновчтой хийж сурах SCORPIO сургалтын аргаар явуулдаг байна.
- Оline сургалт буюу Real-time сургалтуудыг зохион байгуулдаг.

Онцлог зүйл:

- Сургалтыг оюутан төвтэй танхим, лаборатори, эмнэлзүйн дуураймал орчинд дадлагажих, эмнэлгийн орчинд орны дэргэдэх сургалт буюу багшийн удирдлагын дор эмчлүүлэгсдэд асаргаа, сувилгаа хийж явуулдаг.
- Цахим сургалтаар видео, аудио лекц, даалгавар хэлбэрээр оюутанд хүргэж оюутан өөрөө бие даан суралцах боломж, нөхцлийг нь бүрдүүлдэг
- Эмнэлзүйн тохиолдлыг боловсруулан асуудлыг шийдвэрлэх аргыг хэрэглэн оюутан аюулгүй орчинд, сувилахуйн ур чадварыг энгийнээс нарийн төвөгтэй, суурь ур чадвараас төрөлжсөн ур чадвар руу шат дараалан, гүйцэтгэж сурах хүртлээ дахин давтан бие дааж болон харилцан нэг нэгнээсээ суралцан, дүрд тоглож, багаар ажиллан мэдлэг ур чадвараа нэмэгдүүлэхээс гадна хамтран ажиллах, цаг барих, илтгэх, тэмдэглэл хөтлөх, эргэцүүлэн бодож, шүүн тунгаах ур чадваруудаа хөгжүүлж сувилахуйн 5 шатлалыг хэрэгжүүлэх дадалд суралцдаг байна.
- Анатомийн хичээлд цахим сургалтын видеог монгол хэл дээр орчуулан 4D хэлбэрээр бэлтгэж аппликейшн, программ, платформуудыг цахимаар явуулснаар суралцагч орон зайнаас үл хамааран өөрийн боломжит цагтаа олон дахин үзэх боломжтой, оюутанд үлдэх, судлах материал, их сурвалжийн багтаамж их, оюутнуудын мэдээллийн сонголт хийх чадвар хөгжсөн сайн талуудтай байна.

Дүгнэлт: Сувилахуйн хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашиглан олон арга зүйгээр зохион байгуулж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Мэргэжлийн хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг хичээлийн хөтөлбөртэй хамааруулан хэрэгжүүлж байх

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сувилахуйн бакалаврын хөтөлбөрөөр төгссөн оюутнуудын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох шалгалт /лиценз/ болон төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлагыг ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа зэргээр хөндлөнгийн үнэлгээ хийдэг.
- АШУҮИС-ийн захирлын 2021 оны А/19 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын IV бүлэг баталсан “Үнэлгээний аргачлал”, хоёрдугаар хавсралтаар “АШУҮИС-ийн сургалтын технологи, чанарын хяналтын журам”-ын V бүлэг “Үнэлгээ”-ний журам оюутны мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлэх аргачлалыг мөрддөг.
- Журмын хүрээнд хичээлийн хөтөлбөрт оюутныг үнэлэх арга зүй, аргачлал, хэлбэрийг дэлгэрэнгүй тусгасан.
- Суралцагчийн үнэлгээ нь мэдлэг, ур чадвар, хандлагыг дүгнэх үнэлэх, мэдлэг шалгах сорил, гардан үйлдлийн шалгалт, ур чадварыг үнэлэх шалгалт, эмнэлзүйн тохиолдол, шалгах хуудас, стандарт өвчтөнийг сургалтад оролцуулах, дүрд тоглох зэрэг үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг багтаасан хичээлийн хөтөлбөрийг сургуулийн захирал, хөтөлбөрийн дэд хороогоор баталгаажуулан хэрэгжүүлдэг.
- Сургалтын явцад багш хөтөлбөрийн дагуу оюутныг үнэлж үнэлгээг их сургуулийн удирдлага мэдээллийн системд байршуулж, оюутан өөрийн эрхээр хандан үнэлгээгээ мэдэх, хяналт тавих боломжтой.
- Сувилахуйн хөтөлбөрийн үр дүн болох сувилахуйн ур чадвар, хандлагыг олгох даалгаврын санг Блүүмийн таксаномын 6 түвшингээр тодорхойлж, дамжаа бүрд үнэлгээний блюпринтийг тодорхойлсон.
- Улирлын шалгалт хичээлийн онцлог, агуулгаас хамаарч цахим, цаасан сорил, аман шалгалт, өртөөчилсөн аман шалгалт хэлбэрүүдтэй.
- Анги дэвших ба төгсөлтийн шалгалт нь сорил, төлөвлөгдсөн зорилготой эмнэлзүйн шалгалт байх бөгөөд ур чадварын шалгалт нь ерөнхий сувилахуй, төрөлжсөн сувилахуйн хичээлийн агуулгы хамарсан практикт хэрэгжүүлэх сувилахуйн 5 шатлалд суурилсан OSCE буюу өртөөчилсөн гардан шалгалт байна.

Онцлог зүйл:

- Сувилахуйн бакалаврын ангийн оюутнуудын анги дэвших мэргэжлийн суурь шалгалтын мэдлэг үнэлэх шалгалтын сорилын үнэлгээнээс харахад 2021 оны анги дэвших улсын шалгалтын найдвартай байдлын коэффициент 0,97 байгаа нь уг шалгалт найдвартай байдлын шаардлагыг хангасан байна.
- Сувилахуйн бакалаврын хөтөлбөрөөр суралцагсдын Төгсөлтийн онолын шалгалтын сорилын найдвартай байдал өссөн, 2019-2022 оны онолын шалгалтын сорилын найдвартай байдал 0,72-0,92 байгаа нь шаардлага хангасан, найдвартай байдлын дундаж утга 0,85, дундаж хазайлт 0,103, төгсөлтийн шалгалтын сорилын найдвартай байдал статистик ач холбогдол бүхий ялгаатай байна / $p=0.0001$ /

Дүгнэлт:

АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь АУС-ийн Сувилахуйн бакалаврын сургалтын хөтөлбөр Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулалт хийдэг байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

2-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн сургалтын орчин барилга, байгууламж, хичээлийн анги танхим, лаборатори, номын сан нь дээд боловсролын байгууллагад тавигдах нийтлэг шаардлагыг бүрэн хангасан.
- Сургалтын зориулалтын байгууламж нь олон нийт иргэний барилга БНБД31-03-03-д заасан байр, талбайн хэмжээ, эрүүл, аюулгүй байдлын стандарт хангасан орчинд үйл ажиллагаа явуулж байна.
- Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001: 2015 стандартыг 2018 оноос хэрэгжүүлж байна. Дээрх стандартын хэрэгжилтийн хугацаанд байгууллагын байр ашиглалтын нийт зардал 2018-2021 онд нийт 114.5 сая төгрөг тус тус хэмнэгдсэн.
- Байгаль ээлтэй үйл ажиллагааг 2018 оноос нийт багш, ажилчид, оюутнуудын дунд тогтмол зохион байгуулсан ба үр дүнтэй үйл ажиллагааны дүнд усны зардал, цаасны зардал, цахилгааны зардал 2018-2021 онд нийт 149 сая төгрөг хэмнэсэн. Үүнд лед гэрэлтүүлэгтэй болсон. Гар угаалтуурыг мэдрэгчтэй болгосон.
- 2021 онд сургуулийн орчинд ажиллагсад, суралцагсдын эрүүл мэндийг дэмжих, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, орчныг тохижилтыг сайжруулах үүднээс спортын талбайн хашааг 7 622 800 төг, хичээлийн А байрны засвар үйлчилгээг 88 437 229 төг, 2022 онд сүүдрэвч-эко байгуулахад 3 475 000 төг зориулсан байна.

- Хичээлийн байр хангамж хүрэлцээ, ажилчдын ажиллах орчин нөхцөлтэй холбоотой багш ажилчид болон оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгааг авч гарсан үр дүнг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилладаг.

Онцлог зүйл:

- Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001: 2015 стандартын хүрээнд шинэ элсэгч бүр 2 мод, төгсөгч бүр 5 мод тарьдаг. 6 жил болж байна. Нийт 1510 мод тарьсан.
- Тэр бүм модны үндэсний хүрээнд Хараа голын эргээр 1000 бургас тарьсан. Эмийн ургамлын полигонд эхний хагас жил монос модны 220, гүйлс модны 70, хайлаас модны 150 үрээр тариалалт хийж 2022 оны 10 сарын 15 нд 330 агч мод тарьж “Элсэгчдийн төгөл” н суурь тавьсан.
- “Оюутны төсөл”-ийн шалгаруултад Эмзүй-Био анагаахын тэнхимийн оюутны баг нь төслийн уралдаанд 2123560 төгрөгийн төсөвтэй төслийн танилцуулгыг дэвшүүлснээр сургуулийн удирдлагын хүрээнд уг төслийг хэрэгжүүлснээр Relaxing corner нь А блокийн 3 давхарт байршиж, хичээлээ хийх ярилцах ая тухтай орчныг бүрдүүлсэн.
- “Оюутны төсөл”-ийн шалгаруултанд Сувилахуйн тэнхимийн оюутны баг нь төслийн уралдаанд 2187560 төгрөгийн төсөвтэй төслийн танилцуулгыг дэвшүүлснээр удирдлагын хүрээнд уг төслийг хэрэгжүүлснээр “Green heard” төсөл нь сургуулийн Б байрны 2 давхарт байршиж, хичээлээ хийх ярилцах ая тухтай орчныг бүрдүүлсэн байна

Дүгнэлт: АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн сургалтын орчин барилга, байгууламж, хичээлийн анги, танхим, лаборатори, номын сан нь дээд боловсролын байгууллагад тавигдах нийтлэг шаардлагыг бүрэн хангасан байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Оюутнуудтай уулзахад номын сан дүүрдэг, хамт хичээл бие даалтаа хийх орчин байдаггүй, лекцийн өрөөнд оруулдаггүй, компьютерын лабораторид компьютеруудыг ашиглуулдаггүй гэсэн өгүүлэмжтэй байна.
- Wifi Free гэсэн бичигтэй, сургууль бүхэлдээ үнэгүй интернэтэд холбогдох боломжтой гэж байгаа ч оюутнуудын уулзалтаар WIFI бараг байдаггүй, шалгалтын үед ашиглах боломжтой бусад хичээлийн үеэр хаасан байдаг тул өөрийн дата-гаар орж байна гэсэн өгүүлэмжтэй байсан.
- Оюутны хувцасны локер хүрэлцдэггүй.

Зөвлөмж:

- Оюутны чөлөөт цагаа өнгөрөөх, хамт хичээл хийх, интернет орчинг бүрдүүлж coffee shop, эсвэл оюутны амралтын буланг нэмэгдүүлэх.
- Хувцасны локер нэмэгдүүлэх тал дээр анхаарах.
- Оюутны дотуур байранд засвар хийж байгаа нь маш сайн байна. Гэхдээ оюутны хоол хийдэг хэсэг давхар бүрт нэг нэг байдаг нь хүрэлцээгүй байдаг гэсэн.
- Оюутны дотуур байранд ажилладаг хоолны газрын хоолны чанар, аюулгүй байдлыг анхаарах.
- Сувилгааны түүхийг цахимаар хөтлөх чадварт сургаж өгөх хүсэлтүүд ажил олгогчдын зүгээс ирсэн тул E-health программыг сургалтын үйл ажиллагаандаа нэвтрүүлэх тал дээр анхаарах

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалт явуулахад шаардлагатай хичээл практикийн материаллаг нөөц, нэг бүрийн хэрэгсэл, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, виртуал, дижитал видео, аудио эх үүсвэр, сургалт судалгааны лицензтэй программаар бүрэн хангагдсан байна.
- 2017 оноос хойш сургалт судалгааны лабораториудын орчин нөхцөлийг сайжруулж, шинээр зарим лабораториудыг байгуулан, сургалтад шинээр 40-75 инч бүхий 38 дэлгэц, шаардлагатай урвалж бодисоор хангагдсан байна.
- Сургалтад орчин үеийн дэвшилтэт технологитой техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, дижитал видео, аудио эх үүсвэрийг ашиглаж байна. Тухайлбал англи хэл хичээлд ашиглаж буй сурах бичгүүд, хүний биеийн анатоми, монголын түүх, эрүүл ахуй, нийгмийн эрүүл мэнд болон мэргэжлийн хичээлүүд цахим хэлбэрээр хэрэглэгддэг нь оюутны сурах нөхцөлийг хялбаршуулсан байна.
- Багш нар интернэтээр Google Meet, Zoom, Camtasia, Apowersoft, MS Office, Teams, сошиал медиа ашиглан оюутнуудад цахим хичээлээ бэлтгэн хүргэдэг байна.
- Багш нарын хэрэгцээнд зориулсан дотоод интернэтийн сүлжээнд холбогдсон Dell, Aser, Hasee маркийн 226 компьютер, 13 проектор, 55 зурагт, 70 принтер ашиглаж байна.
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх сурвалжийн ашиглалтын хүрээнд цахим номын сангийн фондыг цахим ном, сэтгүүл, эрдэм шинжилгээний бүтээлээр бүрдүүлсэн байна.

Дүгнэлт: Сургалт явуулахад шаардлагатай хичээл практикийн материаллаг нөөц, нэг бүрийн хэрэгсэл, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, виртуал, дижитал видео, аудио эх үүсвэр, сургалт судалгааны лицензтэй программаар бүрэн хангагдсан байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Ур чадварын өрөөний бэлэн байдал хангалтгүй, хэрэглэгдэхүүнийг хичээлийн сэдвээр, хичээлийн агуулгаар байршуулах шаардлагатай байна. Ур чадварын төв эмнэлзүйн талбарыг орлохуйц байх
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллага руу сувилахуйн багш нар өөрсдөө очиж үзэх, судлах
- Зөв үед зөв хэрэглэгдэхүүнийг хэрэглэж чаддаг, мэддэг, хандлагатай төгсөгчийг бэлтгэх
- Эмнэлгүүд хагас бие даасан байдалд шилжиж ажиллаж байгаа энэ цаг үед арвигч хямгач, үргүй зардлыг бууруулах тал дээр анхаарч байгаа тул төгсөгчдийг оновчтой хэрэглэгдэхүүн хэрэглэх дадалд сургах

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- 150 уншигчийн суудалтай номын сангийн 2 танхимтай. Жилдээ 1500-1600 нэр төрлийн 20000-260000 ном сурах бичгийг үйлчилгээнд гарган ажиллаж байна.
- Хичээлийн А байранд 2019 онд “Мэргэн цоохор” 130 суудалтай 263.49 талбайтай уншлагын танхимд номын санчид – ээлжээр 07.30-21.30 хүртэл уншлага үйлчилгээг хүргэдэг.
- Оюутны байранд 54 уншигчийн суудалтай уншлагын танхим 24 цагаар ажиллаж, ном олгох үйлчилгээг оршин суугчдын амьдралын хэвшилд нийцүүлэн 11.00-21.00 цаг хүртэл ажилдаг байна.
- Номын сангийн фондыг В1 давхарт шилжүүлж зориулалтын өрөөтэй болсноор MNS5742:2007 стандартад нийцсэн. Номын сангийн фонд нь нийт 32898 ном, сурах бичиг, гарын авлагатай ба үүнийг хэлний байдлаар ангилбал монгол ном, сурах бичиг 26469, орос ном, сурах бичиг 3206, англи ном 2248, сэтгүүл 703, эрдмийн ажил 272 байна.
- Сувилахуйн хөтөлбөрт ашиглаж буй сурах бичиг 293 төрлийн 4778 ном, сурах бичиг. Суурь хичээлийн 616 нэр төрлийн 6605 ном, сурах бичиг ашиглаж байна. Хамгийн их хэрэглэгдсэн сурах бичиг “Сувилахуйд суралцагсад” сурах бичиг 2 жилийн турш 7365 удаа уншигдсан буюу өдөр бүр 10 ном уншигдаж байна.
- А байрны номын сангийн фондын өрөөг засварлаж, мэдээлэл технологийн арга зүйчдийг хэвлэх, олшруулах үйлчилгээтэй болж багш оюутны цагийг хэмнэсэн.
- Оюутны цахим хаягийг ашиглан уншигчдын групп үүсэж оюутан, хэсэг, поток, дамжаагаагаар нь ялгавартайгаар <http://library.mnums.edu.mn/> КОХА программаас цахим ном захиалах, унших зааврыг нэгдсэн цахим шуудангаар явуулах болон мэдээ , мэдээлэл дамжуулан ажилладаг.
- Сувилахуйн хөтөлбөрийн англи хэл дээрх цахим номын тоо 14 ширхэг байна.

Онцлог зүйл:

- Номын санд мэргэжлийн 3 номын санч үйлчилгээ үзүүлдэг. Ахлах номын санч болон нэг номын санч нь СУИС-ийн Соёлын Боловсролын Сургуулийн Номын сан судлал, мэдээлэл мэргэжлээр төгссөн бол нэг номын санч нь богино хугацааны сургалтаар номын санчийн мэргэжил эзэмшсэн байна.
- Номын санчид нь жил бүр сургуулиас зохион байгуулдаг сэтгэл зүй, ёс зүй, харилцаа хандлагын сургалтанд тогтмол хамрагддаг байна. Мөн сонсголын бэрхшээлтэй уншигчтай харилцах анхан шатны мэдлэгтэй болох зорилгоор Харилцааны анхан шатны дохионы хэлний сургалтанд хамрагдсан байна.
- Эрдэм шинжилгээний Research4life төлбөртэй ашиглаж эхэлсэн.
- Орон нутаг дахь их, дээд сургууль хоорондын мэдээллийн нэгдсэн баазтай болох талаар судалгаа эхэлсэн байна.
- Хүний нөөцийг чадавхжуулах, мэдээлэл технологи программ хангамжийн сургалт болон харилцаа хандлага, англи хэл, мэргэжлийн сургалтад намын санч нараа хамруулж байна.

Дүгнэлт: Багш суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол хангагддаг байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Номын сангийн баяжилтыг хийхдээ шаардлагатай номын тоог нэмэх
- Гадаадад эрдмийн зэрэг хамгаалж байгаа судлаач сувилагч нарын бүтээлийг номын сандаа байршуулах

3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- 2010 оноос сувилахуйн хөтөлбөрийн тогтвортой хөгжлийг хангах, багш нарын тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх, багшийн хөгжил хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж 2022 онд сайжруулан БАГШИЙН ХӨГЖЛИЙН ДЭД ХӨТӨЛБӨР-ийг боловсруулж хэрэгжүүлж байна.
- АШУҮИС-ийн Дархан-Уул дахь салбар АУС-ийн “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” 2021-2025 бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа
- АШУҮИС-ийн захирлын 2016 оны 5-р сарын 19-ны өдрийн А56-р тушаалыг үндэслэн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн хөтөлбөрийн дэд хороо 2017 оны 9 сарын 25ны өдрийн сургуулийн захиралын 81тоот тушаалаар байгуулагдсан.
- Сургалтын чанарыг сайжруулах тухай АШУҮИС-ийн захирлын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/68 дугаар тушаалаар Сургалтын чанарыг сайжруулах, хөтөлбөрийн шинэчлэл хийсэн.
- Сургуулийн захиргааны зөвлөлийн хурлыг 7 хоногт нэг удаа, нийт багш, ажиллагсдын хурлыг сард нэг удаа тогтмол хийж, төлөвлөгөөт болон цаг үеийн асуудлыг хэлэлцэж, сургалттай холбоотой дүрэм журмын хэрэгжилт, сургуулиас хүргүүлсэн зар, мэдээллийг багш нарт хүргэж ажилласан.
- Сургуулийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө 2030-г баримтлан мэргэжлийн тэнхим, албад үйл ажиллагааны төлөвлөлтийг жил удирдлага зохион байгуулалтын чанарыг дээшлүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, сургалтын чанар, орчин, хүртээмжийг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ, инновац, судалгаанд суурилсан инновацыг хөгжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, байгууллагын соёл, олон нийттэй харилцах харилцааг сайжруулах, төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх чиглэлүүдийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн, тоо, чанар, хугацаа гэсэн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр боловсруулан хэрэгжүүлжээ.
- Оюутны санал хүсэлт, гомдол 2022 онд 52 ирснээс цахим хэлбэрээр 24, сургалттай холбоотой 6, оюутны код, цахим хичээлтэй холбоотой 8, цахим номын сан, цайны газар, интернэттэй холбоотой 7, бусад 5, сургалтын төлбөрийн талаар 1, сургуулийн захиргаанд хандсан 1 тавьж буй асуудлын хүрээнээс хамаарч мэргэжлийн тэнхим,

алба, захирлын зөвлөлийн хэмжээнд хүлээн авч шат дараалан 100 хувь шийдвэрлэсэн байна.

- Сургуулийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө 2030-г баримтлан мэргэжлийн тэнхим, албад үйл ажиллагааны төлөвлөлтийг жил бүр 7 чиглэлээр хийж төлөвлөлтийн гүйцэтгэлийг хичээлийн жилд 2 удаа хамт олонд нээлттэй танилцуулж, үр дүнг дүгнэж хэвшжээ.
- Оюутны программыг 2022 онд 970 ашиглаж дахин судлах, дахин шалгалтын 346 оюутны дүн оруулж, давхацсан тоогоор 9700 оюутны сонголт, хичээлийн холболтуудыг хийж, 174 төгсөгчийн дипломын хавсралтуудыг хэвлэжээ.
- ИСУМС нь алба, тэнхим, багш суралцагсад, эцэг эх хоорондын харилцаанд мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглаж ажлын бүтээмжийг дээшлүүлэх, мэдээллийн нэгдсэн сан, тайлан судалгааг бий болгож байгууллагыг зөв, оновчтой удирдан чиглүүлэхэд туслах гол хэрэгсэл болжээ.

Онцлог зүйл:

- 20 гаруй олон улсын байгууллага, сургуулиудтай хамтран ажилладаг.
- 2018-2022 онд гадаадын 11 их сургуультай цахимаар хамтран ажиллах гэрээ байгуулж, 20 гаруй багш, 16 оюутан солилцож, хамтран ЭШХ зохион байгуулах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг хийж байна.
- 2022 онд багш нарт зориулсан анхан, дунд, ахисан түвшний англи хэлний сургалтад 28 багш хамрагдсан.

Дүгнэлт:

АШУУИС-ийн Дархан Уул аймаг дахь салбар АУС -ын сувилахуйн бакалаврын хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангасан байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- 20 гаруй олон улсын байгууллага, сургуультай хамтран ажилладаг.
- Японы Жичи АУС-ийн Сувилахуйн сургуультай хамтран ажиллах гэрээг 2018 онд байгуулж 2 багш, 8 оюутан ирж хамтарсан дадлага, жижиг бүлгийн сургалт зохион байгуулсан.
- 2018 онд хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ, БНСУ, ОХУ-д 16 багш мэргэжил дээшлүүлсэн.
- Европын холбооны ERASMUS хөтөлбөрийн хүрээнд Францын Мулан хотын Улаан загалмайн дэргэдэх сувилахуйн сургуультай хамтарсан багш оюутан солилцоо 11680 еврогийн хөтөлбөрийг 2015-2023 онд тасралтгүй хэрэгжүүлж 14 багш, 8 оюутан явсан.

- JICA олон улсын байгууллагын сайн дурын ажилтнуудтай хамтран төрөлжсөн сувилахуйн чиглэлээр хамтарсан цуврал сургалтуудыг 2019 онд зохион байгуулсан.
- 2018 оноос АНУ-ын Олон улсын хүний нөөцийн солилцооны байгууллагатай /RIE/ хийсэн гэрээний дагуу англи хэлний 2 багш ирж сургалтыг явуулж, 28 багш хамрагдсан.
- 2019 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилттай “Хүн бүрд хүртээмжтэй орчин” төсөл, “10 оюутан-10 хөгжлийн бэрхшээлтэй оюутан төсөл” хэрэгжсэн.
- 2021-2022 онд “Тамхигүй Дархан” төсөл, Дархан-Уул аймгийн Боловсрол соёл, урлагийн газартай хамтран зохион байгуулсан “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын тамхидалт, дам тамхидалтын тархалтын судалгааг хийсэн.
- 2021 онд гадаадын урт болон богино хугацааны 31 удаагийн цахим сургалтад 24 багш хамрагдсан.
- Японы Жичигийн АУС-ийн Сувилахуйн сургуультай хамтарсан “Япон болон Монгол улс дахь ахмад настнуудын эрүүл мэндтэй холбоотой амьдралын чанар, түүнд нөлөөлөх хүчин зүйлс” төсөл, Эмийн ургамалын полигоныг хөгжүүлэх төсөл, Эрүүл мэндийг дэмжих санхүүжилттэй “Дархан-Уул АУС-ийн оюутнуудад зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, замын хөбдөлгөөнд оролцох зөв зан үйлийг төлөвшүүлэх” төсөл 2022 онд бүрэн хэрэгжсэн.
- ДЭМБ, ЭМЯ-тай хамтран “Сувилахуйн боловсролын шинэчлэл” монголын сувилахуйн багш нарын 2-р чуулганг 2019 онд зохион байгуулсан.
- Төгсөгчдийн холбоо 2017,11,24 нд байгуулагдаж үйл ажиллагаа нь тогтмолжиж, багш шавийн уулзалтуудыг 2018 онд Орхон, Сэлэнгэ, Улаанбаатар, Булган хөвсгөл аймгуудад, 2019 онд Дархан-Уул, Архангай, Баянхонгор, Өвөрхангай айигуудад, 2020 онд Дорнод аймагт тус тус зохион байгуулсан.
- Төгсөгчдийг 21 мэргэжлээр төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтад хамруулж 2018-2023 онд нийтдээ 474 сувилагчид нарийн мэргэжил олгосон.

Дүгнэлт: АШУУИС-ийн Дархан Уул аймаг дахь АУС нь дотоод, гадаадын их сургуулиуд, олон улсын байгууллага, эмнэлэгүүд, төгсөгчидтэйгөө холбоо харилцаа тогтоож, багш оюутан солилцоо, тэтгэлэгт хамрагдах, хамтарсан сургалт, судалгааны ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Төгсөгчдийг хөтөлбөрийн шинэчлэлд оролцуулах

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Орлогын 85%-ийг Сургалтын төлбөрийн орлого бүрдүүлдэг.

- 2021 онд 265 сая төгрөг, 2022 онд 478 сая төгрөг, 2022 онд 369 сая төгрөгийн тэтгэлэг олгогдсон тэтгэлэг төрөөс олгогдсон.
- Төсвийн гүйцэтгэлээр 2015 онд 280 сая төгрөг, 2016 онд 232,96 сая төгрөг, 2017 онд 319 сая төгрөг, 2018 онд 274 сая төгрөг, 2020 онд 372 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан.
- БШУЯ-ы Боловсролын зээлийн сангаас буцалтгүй тусламж, оюутны хөгжлийн зээл, тэтгэлэгт оюутнуудаа хамруулж, сүүлийн 5 жилд 1,973 сая төгрөгийн санхүүжилт авсан.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар спорт заал, оюутны байрны их засварын ажлыг хийж байна.

Онцлог зүйл:

- Төрөөс төлбөрийн санхүүжилттэй.
- Шинэ сэргэлтийн бодлого -орон нутагт суралцагсдын сургалтын төлбөр 50% төрөөс даадаг.

Дүгнэлт: АШУҮИС-ийн Дархан Уул аймаг дахь салбар АУС нь бие даасан хуулийн этгээдийн эрх эдлэх мэдэлтэй байх зохицуулалт бүрдсэн.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Санхүүгийн эх үүсвэрийн дийлэнх хувийг төрөөс сургалтын төлбөрийн санхүүжилтын орлого эзэлж байна. Иймээс олон эх үүсвэрийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- 2017 оноос төгсөгчдийн холбоогоор дамжуулан төгсөгчдийн мөшгөх судалгаанууд, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаануудыг зохион байгуулдаг.
- Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулдаг 60 байгуулага, 12 эмнэлэг дээр сургууль, хөтөлбөр, танилцуулах нээлттэй өдөрлөг зохион байгуулсан.
- Сургууль, хөтөлбөр, мэргэжил сурталчлах, нээлттэй өдөрлөгүүдийг байнга тогтмол зохион байгуулж хэвшсэн.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төвөөр дамжуулан 204 оюутныг 11 сая төгрөгийн орлоготой ажилд зуучилж оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн.
- Жил бүр “Мэргэжил сурталчлах өдөрлөгийг, шинээр элсэгчдэд хөтөлбөрийн мэдээлэл бүхий танилцуулга, цахим хэлбэрээр сургуулийн вэб сайтаар дамжуулан хөтөлбөрийг сурталчилдаг.

Дүгнэлт: АШУҮИС-ийн Дархан Уул аймаг дахь АУС нь Сувилахуйн мэргэжлийн бакалаврын хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц сурталчилгаа хийдэг

Үнэлгээ: Бүрэн хангасан

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сувилахуйн мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөрийг нээлттэй их сургууль зорилгын хүрээнд сургуулийн вэб сайтыг шинэчлэн зохион байгуулж англи, монгол хэлний хувилбартайгаар 2021 онд их сургуулийн brandimage-г шингээн шинэчилсэн.
- “Дархан Анагаах ухаан” цахим сонины 12 дугаар гаргасан.

Дүгнэлт: АШУҮИС-ийн Дархан Уул аймаг дахь АУС нь Сувилахуйн мэргэжлийн бакалаврын хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, ил тод байдлыг ханган сургуулийн вэб хуудсаар, цахим сонины багшийн хөгжил булангаар түгээдэг байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Нэгдсэн вэб хуудаснаас хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжгүй байгааг анхаарах
- <https://mnums-da.edu.mn> сайтын зарим мэдээлэл хуучирсан байгааг шинэчлэх

4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн захирлын 2023 оны А/109 тоот тушаалаар баталсан “Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам”-ын тушаалуудыг үндэслэн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуульд оюутан элсүүлэх журмыг шинэчлэн мөрддөг. Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд багтсан хөтөлбөрүүдээр элсэн суралцах оюутны хяналтын тоог АШУҮИС-ийн удирдах зөвлөлөөс тогтоож АШУҮИС-ийн захирлын тушаалаар баталж хэрэгжилтийг хангадаг.
- 2020 оноос элсэлтийн үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжиж элсэлтийн журам, элсэлттэй холбоотой багц мэдээлэл, оюутанд үзүүлэх тэтгэлэг, урамшуулал, оюутны клубүүд, оюутны дотуур байр, оюутан солилцоо хөтөлбөр зэрэг оюутанд чиглэсэн мэдээллийг сургуулийн <https://mnums-da.edu.mn/> веб сайтанд байршуулан, элсэлт цэсний цахим бүртгэлээр бүртгүүлэх боломжтой болсон.

- Сүүлийн 5 жилд сувилахуйн бакалаврын хөтөлбөрөөр 211 суралцагч элсэн суралцсан бөгөөд элсэгчийн тоо болон босго оноо тогтмол өссөн.

Онцлог зүйл:

- Шинээр элсэн орсон оюутнуудад 07 хоногт Удиртгал хичээлийг танхим болон цахимаар зохион байгуулж, олон талын мэдээллийг олгодог. “Оюутны хөтөч” гарын авлагыг боловсруулан хүргэдэг бөгөөд энэ хичээлийн жилээс цахим хэлбэрээр хүргэдэг болсон.
- Сувилахуйн хөтөлбөрөөр элссэн хөгжлийн бэрхшээлтэй элсэгчдэд захирлын зөвлөлийн хурлын шийдвэрээр сургуулийн дотуур байрны төлбөрөөс 100 хувь чөлөөлдөг. 2021 оноос хойш сувилахуйн хөтөлбөрөөр суралцагч 3 оюутанд уг хөнгөлөлтийг олгосон.
- Бүртгүүлээд элсэн орж буй элсэгчдийг тогтмол “Сайхан сэтгэл” сургуулийн үүдэн эмнэлэгт хөнгөлөлттэй үнээр үзлэг, оношлогоонд хамруулдаг.
- Элсэгчдэд үзүүлэх хөнгөлөлт урамшуулалд элсэлтийн ерөнхий шалгалтад хими, биологийн хичээл тус бүрээр 501 ба түүнээс дээш оноо авсан тохиолдолд хичээлийн жилийн эхний улирлын сургалтын төлбөрийг 100 хувь хөнгөлдөг. Мөн сувилахуйн бакалаврын хөтөлбөр дээр элсэлтийн оноогоор хамгийн өндөр оноотой элсэгчийг шалгаруулан шилдэг элсэгч батламжийг гардуулан, сургалтын хэрэглэгдэхүүнээр урамшуулдаг.
- Орон нутагт элсэн суралцаж байгаа бакалаврын хөтөлбөрийн оюутнуудын төлбөрийг улсаас 50 хувь хөнгөлдөг.

Дүгнэлт: АШУҮИС-ийн захирлын 2023 оны А/109 тоот тушаалаар баталсан “Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам”-ын тушаалуудыг үндэслэн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуульд оюутан элсүүлэх журмыг шинэчлэн мөрддөг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- <https://mnums-da.edu.mn/> сайтанд элсэлттэй холбоотой мэдээлэл болон элсэлтийн журмыг шинэчлэн оруулдаг байх

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутанд зориулан жил бүр сургуулийн хэмжээнд сургалт, хүмүүжлийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан захирлын зөвлөлөөр батлуулан хэрэгжүүлдэг. Үүний хүрээнд жилд 40-48 ажлыг зохион байгуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг холбогдох алба, мэргэжлийн тэнхим, байгуулагдсан ажлын хэсгүүд хангаж ажилладаг.
- Оюутны хөтөч гарын авлага дотор тухайн жилийн сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг тусган хүргэдэг.
- АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургуулийн захирлын тушаалаар “Зөвлөх багшийн ажиллах журам”-ийн дагуу анги удирдсан багшийг томилон, нийт

12 үзүүлэлтээр хичээлийн жилийн эцэст үнэлж, багшийн мэргэжлийн оноонд тооцдог.

- Оюутны дотуур байрны багш сургуулийн дотоод журам, дотуур байрны журамд заасан үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Сүүлийн 5 жилд давхардсан тоогоор 1303 оюутан байрласан бөгөөд 778 буюу 59.7 хувь сувилахуйн хөтөлбөрөөр суралцагч оюутнууд байна. Үүнээс 441 оюутан нь бакалаврын хөтөлбөрөөр суралцагч байна.
- 2019 оноос Дархан-Уул аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй их дээд сургууль, мэргэжлийн сургуулийн оюутнуудад сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвийг сургуулийн “Сайхан сэтгэл” эмнэлгийн дэргэд байгуулан нийт 26 удаагийн уулзалт, сургалтыг зохион байгуулж, 49 оюутанд сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн.
- Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газартай хамтран оюутнуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гал түймрээс урьдчилан сэргийлэх, галын аюулгүй байдлын тухай хууль, авилга, ашиг сонирхолын зөрчлөөс сэргийлэх хуулийг сурталчлах ажлыг жил бүр зохион байгуулж хэвшсэн.
- “Судлаач оюутан” эрдэм шинжилгээний хурлыг уламжлал болгон зохион байгуулдаг. Сүүлийн 5 жилд сувилахуйн бакалаврын хөтөлбөрийн багш оюутнуудын хамтарсан 14 илтгэл хэлэлцүүлэн хэвлүүлсэн.

Онцлог зүйл:

- 2019 оноос оюутны дадлагажилтанд сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний оролцоо, хамтын ажиллагааны хүрээнд Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран ахлах сувилагч нар болон ур чадварын хичээл үзэж дууссан 2 дамжааны оюутнуудын дунд “Цагаан малгай ёслол” хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулдаг. Үүний дараа “Нэг сувилагч-Нэг оюутан” шавьлан сургах хөтөлбөрийн дагуу ахлах сувилагч нартай холбоо тогтоон оюутнууд эмнэлэгийн орчинд дадлага хийх боломжийг бий болгон үүгээрээ дамжуулан зөвлөн тусалдаг.
- 2019 оноос эхлэн төгсөх ангийн оюутнуудад ажлын байран дээр гарахын өмнө “Шинэ сувилагчийн ажлын гараа-туршлагаасаа хуваалцах нь” хэлэлцүүлгийг өөрийн төгссөн олон жил ажилласан сувилагч нарыг урьж хэлэлцүүлэг хийж сэтгэл зүйг бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулдаг.
- 2018 оноос эхлэн ERASMUS mobility хөтөлбөрийн хүрээнд Францын Мулан хотын Улаан загалмайн дэргэдэх Сувилахуйн сургуультай харилцан туршлага солилцох хөтөлбөр хэрэгжүүлэн 5 багш, диплом болон бакалаврын ангиас 6 оюутан туршлага солилцсон. Энэ хөтөлбөрийн хүрээнд сургуулийн хэмжээнд оюутны санаачлагатай төсөл болон оюутан төвтэй сургалтыг зохион байгуулах туршлагуудыг сургалтад нэвтрүүлсэн.
- 2018 оноос уламжлал болгон оюутнуудын нийгэмшил, төлөвшил, хөгжил, оролцоо, түүний ач холбогдлыг таниулах “Профессорын цаг” сургалтыг тогтмол зохион явуулж байна.

Дүгнэлт: Оюутанд зориулан жил бүр сургуулийн хэмжээнд сургалт, хүмүүжлийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан захирлын зөвлөлөөр батлуулан хэрэгжүүлдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- 2017-2022 оны оюутны сэтгэл ханамжийн судалгаанд “хичээлээс бусад цагт зөвлөн тусалдаг” асуулгын үр дүнгийн тийм хариултын дундаж 65.6 хувь байгаа нь бусад үзүүлэлтээс бага байгаад цаашид анхааран зөвлөн туслах үйлчилгээг сайжруулах
- Оюутанд зориулсан үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар оюутнуудаас судалгаа авч сайжруулдаг байх
- Оюутанд зориулан хийгдэж буй үйл ажиллагаа нь хөтөлбөрийн 10 цогц чадамж руу чиглэж буйд анализ хийх

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Нийт анги хэсгийн дарга нараас бүрдсэн 3 баг бүхий оюутны зөвлөл, 19 клуб идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Үүнээс Сувилахуй энэрхүй, ABCD, Ногоон байгууламж бидний ирээдүй 3 клубыг сувилахуйн мэргэжлийн оюутнууд санаачлан хэрэгжүүлдэг. Чиглүүлэгч багш нар сувилахуйн тэнхмийн багш нар ажилладаг.
- 2021 оноос оюутны санаачлагын тэтгэлэгт төслийн уралдааныг зарлан сүүлийн 3 жилд сувилахуйн диплом болон бакалаврын хөтөлбөрөөр суралцагчидын 2021-2022 оны хичээлийн жилд “Green heart”, “Эрүүл шүд-Эрүүл оюутан” төслүүд шалгаран 2,900.000 төгрөг буюу Эрдэм шинжилгээний ажлын нийт зардлын 4.3 хувь, 2022-2023 оны хичээлийн жилд “Ногоон байгууламж бидний ирээдүй” төсөл шалгаран 2,100.000 төгрөгийн санхүүжилт авсан нь Эрдэм шинжилгээний ажлын зардлын 6.6 хувийг тус тус зарцуулсан байна.
- АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар АУС-ийн оюутанд тэтгэлэг олгох журмын дагуу шилдэг сурлагатан, шилдэг авъяастан, шилдэг спортлог, манлайлагч, шилдгийн шилдэг 5 номинацаар шалгаруулан 2017-2021 онуудад нийт 40 оюутан 20 сая төгрөгийн урамшуулал олгосон.
- Засгийн газрын 346 тогтоолоор 2022-2023 оны хичээлийн жилд 524 оюутан давхардсан тоогоор тэтгэлэг авсан.

Онцлог зүйл:

- 2018 оноос “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг байгуулан оюутны зөвлөлтэй хамтран хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажилладаг
- 2021-2022 оны хичээлийн жилд 23 оюутан хүүхэд харах, цэвэрлэгээ, зөөгч, асрагч, ургац хураалт, худалдагч зэрэг ажлуудыг хийж 7.090.000 төгрөгний цалин урамшуулал авсан. 2022-2023 оны хичээлийн жилд ургац хураах ажилд 46 оюутан ажиллаж 8.685.000 төгрөгийн цалин урамшуулал, бусад чиглэлээр 13 оюутан 10.310.000 төгрөгийн цалин авсан байна.
- Дархан-Уул аймаг дахь АУС-ийн түүхт 50 жилийн ойд зориулсан сувилагч мэргэжлээр суралцаж буй оюутнуудын дунд сувилахуйн ур чадварын улсын анхдугаар олимпиадыг зохион байгуулан, энэ тэмцээндээ 2019 онд дэд байр, 2023 онд тусгай байрыг эзэлсэн. Үүнээс гадна 2017-2019 оны хооронд “Чадварлаг оюутан” сувилахуйн ур чадварын тэмцээнийг зохион байгуулдаг байсныг 2019 оноос эхлэн энэ тэмцээнийг өргөжүүлэн ахмад багш клиник болон дэд профессор Х.Амаржаргал багшийн нэрэмжит “Сувилах эрдэм” сувилахуйн ур чадварын тэмцээнийг уламжлал болгон зохион байгуулж байна.

Дүгнэлт: “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг байгуулан оюутны зөвлөлтэй хамтран хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажилладаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Оюутны өөрөө удирдах байгууллага болон клубийн зохион байгуулсан үйл ажиллагаа бүрийн давуу болон сул талыг тодорхойлон тайлагнаж үр дүнг тооцдог байх

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Шилжилт хөдөлгөөний журмын дагуу заалтуудыг үндэслэн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэдэг. Хөтөлбөр хооронд шилжин суралцах оюутан “Багц цаг дүйцүүлэн тооцох журам”-ын дагуу хөтөлбөрийг Сургалтын алба дүйцүүлэн тооцдог. Дүйцүүлэн тооцох шаардлага хангахгүй тохиолдолд хөтөлбөрийн багц цагийн зөрүүг заавал нөхөн суралцана.
- Сувилахуйн бакалаврын хөтөлбөрөөр сүүлийн 5 жилд жилийн чөлөө авсан оюутны тоо 51, жилийн чөлөөнөөс эргэн суралцсан оюутны тоо 34, хөтөлбөр сольж суралцсан оюутны тоо 17, өөр сургуулиас ирсэн оюутны тоо 8, сургуулиас гарсан оюутны тоо 18, сургуулиас хассан (нас барсан) оюутны тоо 1 байна.

Дүгнэлт: Шилжилт хөдөлгөөний журмын дагуу заалтуудыг үндэслэн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой шалтгааныг тодруулдаг байх
- Элсэн орсон суралцагчдаас хэдэн хувь нь төгсөж байгаад мониторинг хийдэг байх

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Сувилахуйн хөтөлбөрийг бүрэн дүүргэсэн оюутнуудын төгсөлтийн баримт бичгийн загварыг 2012 оны 1-р сарын 2-ны өдрийн 01 дугаартай БСШУЯ-ны “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” тушаалын 1-р хавсралтын дагуу хийж гүйцэтгэдэг.
- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 01-р сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах

журам”-ын 7-р бүлэг, АШУҮИС-ийн дүрмийн 4.8.1, 4.8.5 дахь заалт, захиргааны зөвлөлийн 2021 оны 01-р сарын 22-ны өдрийн 21/1 тоот хурлын шийдвэрийг үндэслэн зохион байгуулдаг.

- Сүүлийн 5 жилд сувилахуйн бакалаврын хөтөлбөрөөр 204 төгсөлтийн баримт бичгийг боловсруулсан.

Онцлог зүйл:

- 2022-2023 оны хичээлийн жилээс төгсөгч нь бүх хичээл 75 хувиас дээш хувьд А үнэлэгдсэн, бусад хичээл В үнэлэгдсэн, голч дүн нь 3.8 болон түүнээс дээш, дахин шалгалт өгч байгаагүй болзол хангасан тохиолдолд онцгойлох диплом олгодог.
- Төгсөлтийн баримт бичиг болох диплом нь кирилл, уйгуржин, англи хэлбэрээр хэвлэгдэн гардаг.

Дүгнэлт: Төгсөлтийн баримт бичгийн загварыг 2012 оны 1-р сарын 2-ны өдрийн 01 дугаартай БСШУЯ-ны “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” тушаалын 1-р хавсралтын дагуу хийж гүйцэтгэдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

5-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийг сонгон шалгаруулах, багшийн ажлын үнэлгээ, гүйцэтгэлийг тооцохдоо АШУҮИС-ийн захирлын 2021 оны 05 сарын 13-ны өдрийн А/103 тоот тушаалаар батлагдсан “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам”-ын дагуу хэрэгжүүлдэг.
- Багшийн сонгон шалгаруулахдаа тэнхмийн хурлын тэмдэглэл, сургалтын албанаас гаргасан тэнхмийн хурлын тэмдэглэл, сургалтын албанаас гаргасан тэнхмийн урьдчилсан цагийн ачаалалд үндэслэн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, ЗХШҮА-нд саналыг хүргүүлдэг. Саналд үндэслэн ЗХШҮА ажлын байрны зарыг 14-21 хоногт олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан зарлаж шалгаруулалтыг сорилын шалгалт, ярилцлага гэсэн 2 үе шаттай зохион байгуулдаг. Нотлох баримтаар багшийг сонгон шалгаруулахдаа тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, хугацааг тодорхой заасан зарыг байршуулдаг. Сорилын шалгалт мэргэжил 50 хувь, англи хэл 30 хувь, ёс зүй 20 хувь байхаар тусган хэрэгжүүлдэг.
- Сувилахуйн бакалаврын хөтөлбөр хэрэгжүүлэгч нийт 29 багшийн 17.3 хувь нь доктор болон түүнээс дээш зэрэг цолтой, 82.7 хувь нь магистр байна. Харин

сувилахуйн дипломын хөтөлбөр хэрэгжүүлэгч нийт 22 багшийн 18.1 хувь нь докторын зэрэгтэй, үлдсэн хувь нь магистр зэрэгтэй байна.

- Багшлах бүрэлдэхүүний хувьд 50 хувийн гэрээт багш 1, дадлагажигч багш 1, сувилагч багш 8 хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар 100 хувь үндсэн багшаас бүрдэж байна.

Онцлог зүйл:

- Албан тушаалын хувьд 10.3 хувь нь дэд профессор, 44.8 хувь нь ахлах багш, 27.5 хувь нь багш, 17.2 хувь нь дадлагажигч багшийн албан тушаалд ажилладаг.
- 2022-2023 оны хичээлийн жилд сувилахуйн бакалаврын хөтөлбөрөөр 164 (1-р дамжаанд 67, 2-р дамжаанд 48, 3-р дамжаанд 42, 4-р дамжаанд 7) оюутан суралцаж байгаа бөгөөд багш оюутны тоон харьцаа 1:6, сувилахуйн дипломын хөтөлбөр 248 (1-р дамжаанд 51, 2-р дамжаанд 82, 3-р дамжаанд 115) оюутан суралцаж байгаа бөгөөд багш оюутны тоон харьцаа 1:11 байгаа нь зохистой харьцаатай байна.
- Багшийн хөгжлийн дэд хөтөлбөрийн хүрээнд 2020-2022 оны шилдэг ном сурах бичиг, шилдэг илтгэл, зохиогчийн эрх, IF сэтгүүл, шилдэг цахим хичээл, шилдэг арга зүйч, шилдэг залуу арга зүйч шалгаруулан 56 багшид 15.848.020 олгосоноос сувилахуйн диплом болон бакалаврын хөтөлбөрт давхардсан тоогоор 28 багш 9.832.116 төгрөгийн урамшуулал олгосон.

Дүгнэлт: Багшийг сонгон шалгаруулах, багшийн ажлын үнэлгээ, гүйцэтгэлийг тооцохдоо АШУҮИС-ийн захирлын 2021 оны 05 сарын 13-ны өдрийн А/103 тоот тушаалаар батлагдсан “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам”-ын дагуу хэрэгжүүлдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Одоогоор сувилахуйн мэргэжлээр 2 багш докторын сургалтад Япон болон Солонгос улсад суралцаж байгаа боловч хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын дунд сувилахуйн мэргэжлийн доктор зэрэгтэй багш байхгүй байгааг цаашид анхаарах
- Сувилагч мэргэжилтэй багшийн тоог нэмэгдүүлэх

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн хөгжлийн дэд хөтөлбөрийн хүрээнд АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Их Сургуулийн захирлын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн “Багшийн хөгжлийн дэд хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” А/10 тоот тушаалын дагуу доорх 5 үзүүлэлтээр багшийн хөгжлийг дэмжин, урамшуулж хэрэгжилтийг тогтмол үнэлдэг. Үүнд:
 1. Шилдэг хүний нөөц бүрдүүлж, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих
 2. Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ур чадварыг хөгжүүлэх
 3. Багшийн мэргэжлийн болон нийгмийн үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх
 4. Багшийн англи хэлний чадавхийг нэмэгдүүлэх
 5. Багшийн академик соёл, ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, хувь хүний мэдлэг, чадвар, хандлагыг хөгжүүлэх

- Дотоодод сүүлийн 5 жилд:
 - Мэргэжлийн сургалт 8 сэдвээр давхардсан тоогоор 16 багш
 - Багш хөгжлийн төвийн сургалт 3 сэдвээр давхардаагүй тоогоор 12 багш
 - Судалгааны арга зүйн сургалт 4 сэдвээр давхардаагүй тоогоор 13 багш
 - Англи хэлний сургалт 3 сэдвээр давхардаагүй тоогоор 9 багш
 - Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт 5 сэдвээр давхардсан тоогоор 18 багш
 - Бусад сургалт 7 сэдвээр давхардсан тоогоор 11 багш нийт 30 сэдвээр давхардсан тоогоор 79 багш хамрагдсан байна. Харин гадаадад сүүлийн 5 жилд 9 чиглэл болон эрдэм шинжилгээний хуралд 12 багш хамрагдсан байна.
- Сувилахуйн диплом болон бакалаврын хөтөлбөрийн багшлах бүрэлдэхүүнээс сургалтын үйл ажиллагаа, хувь хүний хөгжил, судалгааны чадавх 3 үндсэн чиглэлээр 2021-2022 оны хичээлийн жилд сургалтын хэрэгцээг тодорхойлон нийт 18 төрлийн сургалтад давхардсан тоогоор 25 багш хамрагдсан.

Онцлог зүйл:

- Багш нарын дунд мэргэжлийн ур чадварын тэмцээн болон шилдэг бүтээл шалгаруулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж урамшуулдаг.
- Докторантурын сургалтад амжилттай суралцаж буй 14 багш ажилчдад зөөврийн болон суурин компьютерийн дэмжлэг үзүүлсэн.
- АШУҮС-ийн докторын хөтөлбөрт хамрагдахад 30 хувийн тэтгэлэг олгон орон нутгаас Улаанбаатар хотод суралцахад сургалтын ачааллыг тооцон, явж сурах боломжийг олгон, цалинг бүтэн олгодог.

Дүгнэлт: “Багшийн хөгжлийн дэд хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” А/10 тоот тушаалын дагуу доорх 5 үзүүлэлтээр багшийн хөгжлийг дэмжин, урамшуулж хэрэгжилтийг тогтмол үнэлдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн хөгжлийн дэд хөтөлбөрийн хүрээнд АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Их Сургуулийн захирлын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн “Багшийн хөгжлийн дэд хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” А/10 тоот тушаалын 2.2 Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ур чадварыг хөгжүүлэх заалтын хүрээнд эрдмийн цол хүртэх, докторын зэрэг хамгаалах, олон улсын мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, үндэсний хэмжээний сурах бичиг хэвлүүлэх, оюуны өмчийн эрх авах 5 үзүүлэлтээр үр дүнг тооцон, урамшуулал олгодог.
- Сүүлийн 5 жилд сувилахуйн диплом болон бакалаврын хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар гадаад өгүүлэл 11, дотоодод 51, илтгэл дотоодод 62, гадаадад 43, ном, сурах бичиг, гарын авлага, сэтгүүл нийт 27 бүтээлийг хэвлүүлэн, зохиогчийн эрх,

гэрчилгээ 7 авсан. Дотоод болон гадаадын байгууллагатай хамтран 3 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Онцлог зүйл:

- АШУҮИС-ийн Дархан уул аймаг дахь салбар Анагаах Ухааны сургуулийг хөгжүүлэх “Стратеги төлөвлөгөө 2030”-д “Эрдэм шинжилгээ, судалгааны орчныг бүрдүүлэх, олон улсын жишигт хүргэх” зорилтыг дэвшүүлэн 2030 хүртэл хэмжих үзүүлэлтийг тодорхойлон хэрэгжүүлж байна.
- Олон улс, улсын болон сургуулийн хэмжээнд жил бүр 6-аас доошгүй хурлыг тогтмол зохион байгуулдаг.
- Олон улсын номын сангийн холбооны бүртгэл ISBN эрх бүхий “Дээд боловсролын эрин үе” сэтгүүлийг бусад их дээд сургуулиудтай хамтран жил тутам эрхлэн гаргадаг.
- Сүүлийн 5 жилд өгүүлэл гадаадад 22, дотоодод 303, илтгэл гадаадад 146, дотоодод 312, ном сурах бичиг, гарын авлага 30 хэвлүүлсэн. Зохиогчийн эрх 20 авсан байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Багш нарын судалгаа шинжилгээний ажлын үр дүнгээс хөтөлбөрийн сайжруулалтад тусгадаг байх

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 05 сарын 13-ны өдрийн “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох ”А/103 тоот журмын 3.8-д заасны дагуу профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш албан тушаалын зэрэглэлийн дагуу сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа, тэнхимийн эрхлэгчийн үнэлгээ, оюутны үнэлгээ 5 чиглэлээр 100 оноонд дүйцүүлэн үнэлж, 80-аас дээш бол сайн, 70-79 оноо бол хангалттай, 69-өөс бага бол хангалтгүй гэж үнэлдэг.
- Дадлагажигч багш, багш 3 жил тутам, ахлах багш, дэд профессор багш 4 жил тутамд өөрийн үнэлгээний тайланг нотлох баримтаар баталгаажуулан АШУҮИС-ийн Багшийн хөгжил цахим сургалтын газрын ажлын хэсгээр хөндлөнгийн үнэлгээг батлагдсан шалгуур хуудсаар хийдэг. Хөндлөнгийн үнэлгээний дүн нь багшийн албан тушаалын зэрэглэл дэвших, буурах үндэслэл болдог.
- Сувилахуй хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нараас 2018, 2022 онуудад дээрх заалтын дагуу захирлын тушаалаар хугацаа болсон багш нар 3 бүлгээр нотлох баримтаа бүрдүүлэн багшийн ажлын үнэлгээний зөвлөл, тэнхимийн эрхлэгч, оюутны үнэлгээний үзүүлэлтээр ахлах багшаас дэд профессор зэрэглэл ахисан 2 багш, багшаас ахлах багшийн зэрэглэл ахисан 3 багш, дадлагжигч багшаас багшийн зэрэглэл ахисан 1 багш нийт 6 багш албан тушаалын зэрэглэл ахисан.

Онцлог зүйл:

- Жил бүр сургалтын албанаас улирал бүр 10 багц асуулгаар оюутны сэтгэл ханамжийн судалгааг авч үр дүнг багш бүрт илгээдэг. Сүүлийн 4 жилийн судалгааны үр дүнгийн дундаж тийм гэж хариулсан үзүүлэлт 79.19 байна.

Дүгнэлт: АШУҮИС-ийн захирлын 2021 оны 05 сарын 13-ны өдрийн “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох ”А/103 тоот журмын дагуу өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг хийдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Багшийн өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээг жил тутамд хийдэг байх
- Оюутнаас авч буй хөндлөнгийн үнэлгээг имэйл хаягаар биш, нууцлалын зэрэглэлтэй байдлаар авдаг байх
- Гүйцэтгэлээс хамаарсан урамшууллын тогтолцоог бий болгох
- Багш нарын нийгмийн асуудлыг дэмжих бодит ажлуудыг бий болгож, тогтмолжуулах

6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- 2017 оноос чанарын менежментийн тогтолцооны олон улсын ISO9001: 2015 стандартыг сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжүүлэлт, үнэлгээ, хөгжүүлэлтийн чиглэлээр чанарын баталгаажилтыг хийж байна.
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хангах зорилгоор Хөтөлбөрийн дэд хороог 2017 оны 9 сарын 25-ны А/81 тоот тушаалаар байгуулагдсан, 2022 оны 3 сарын 2-ны А/10 шинэчлэгдсэн (ажил олгогчдын төлөөлөл, төгсөгчдийн төлөөлөл орсон) 2022 оны 11 сарын 16 ны А/87 тоот тушаалаар “Хөтөлбөрийн дэд хорооны үйл ажиллагааг зохицуулах журам” шинэчлэгдсэн (дотоодын болон гадаадын магадлан итгэмжлэлийг хороо хариуцна гэсэн заалт нэмэгдсэн)
- Хөтөлбөрийн дэд хороо нь хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажилтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг хийдэг.
- Сувилагч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг 2022 оны 11 сараас сургуулийн хөтөлбөрийн дэд хороо 3 удаа хэлэлцсэн байна.

- Чанарын менежментийн тогтолцооны MNSISO 9001:2016 стандартын хэрэгжилтийн хүрээнд Чанарын удирдлагын хороог 2017 оны 10 сарын 3 ны захирлын 95 тоот тушаалаар баталсан. Чанарын нэгдүгээр баг, хоёрдугаар баг, гуравдугаар баг, дөрөвдүгээр багуудыг томилж жил бүр төлөвлөгөө боловсруулж дотоод аудит хийж ажилдаг.
- Дотоод аудитын баг нь байгууллагын дотоод чанарын тогтолцоог үйл явцыг тасралтгүй хангах бодлого, дүрэм журмыг баримтлан чанарын дотоод хяналтыг төлөвлөгөөний дагуу тогтмол хийж дүрэм, журмыг хэрэгжүүлэн, мөрдөж ажиллаж, байнгын сайжруулалтыг хийдэг байна.
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт нь хөтөлбөрийн үнэлгээ болон хичээлийн үр дүнгээ тогтмол үнэлж, эргэх холбоог хөгжүүлэн багш, суралцагч, төгсөгч, элсэгч, ажил олгогчдоос үе шаттай авсан судалгааны үр дүнгээ тооцож, нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлага, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн тасралтгүй сайжруулалт хийж ажилдаг байна.
- Дотоод аудитын хөтөлбөртэй, дотоод аудитын багаас аудит хийх хэсэгт дотоод аудит хийх хүсэлт хүргүүлдэг. Дотоодын аудитын төлөвлөгөөг танилцуулж хүргүүлдэг. Онол дадлага, семинарын хичээл хөтлөн явуулах үйл ажиллагаанд дотоод аудит хийх шалгах хуудсаар үнэлгээ хийнэ. Үнэлгээний явцад үл тохирол илэрсэн тохиолдолд тайланг нэгтгэж эргэн мэдээлдэг. Үл тохирол 2 төрөл байдаг: ЖҮТ- жижиг үл тохирол (Шалгах хуудсаар илэрсэн үл тохирол) ТҮТ- том үл тохирол (ISO 9001:2015 стандартын шаардлагыг зөрчсөн тохиолдлыг хэлдэг байна.
- Тайланд илэрсэн үл тохирол, үл тохирлыг залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааг зааж өгдөг. Үл тохирлыг залруулсан арга хэмжээний тэмдэглэлийг эргэн хугацаанд нь мэдээлдэг. Нэг удаагийн дотоод аудитаар илэрсэн үл тохирлын нэгдсэн дүнг Удирдлагын дүн шинжилгээний хурал, захирлын зөвлөлийн хурлаар танилцуулдаг.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарын баталгаажуулалтын хүрээнд Сургалтын албанаас суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааг жил бүр гаргаж, үр дүнг сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажилладаг.
- Оюутны сэтгэл ханамжийн үнэлгээ Ликертын оноогоор нэгтгэсэн дүнд 2017 онд 2.48 байсан бол 2021 онд 3.32 болж өссөн дүнтэй байна. Багшийн сэтгэл ханамж 2017-2021 онуудад 2.27-3.26 болж өссөн байна. Ажил олгогчийн сэтгэл ханамж тус онуудад 2.53-3.95 болж өссөн байна.

Онцлог зүйл:

- Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO9001:2016 стандартын гарын авлагыг АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн захирлын зөвлөлийн 2020 оны 10 сарын 09 ний өдрийн , Чанарын хорооны 2017 оны 10 сарын 09 ны өдрийн хурлаар хэлэлцэн баталж хэвлүүлэн гаргасан байна.
- Байгаль орчны менежментийн тогтолцооны гарын авлагыг АШУҮИС-ийн Дархан –Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн захирлын зөвлөлийн 2018 оны 12-р сарын 09-ний өдрийн, чанарын хорооны 2018 оны 12-р сарын 03-ны өдрийн хурлаар баталж хэвлэж гаргасан байна.

Дүгнэлт: Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтыг хэрэгжүүлдэг тогтоцоотой байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

- 2017 оноос эхлэн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл өөрчлөлт, хөдөлгөөн, ажлын байранд тулгарч буй бэрхшээл болон ажилгүй байгаа шалтгаан зэргийг бодитойгоор илрүүлэх зорилгоор төгсөгчдийн мөшгөх судалгаа-1, төгсөгчдийг мөшгөх судалгаа -2, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийсэн байна.
- Судалгаагаар 2019 оны төгсөгчдийн 30.2 хувь, 2020 оны төгсөгчдийн 37.2 хувь нь төгссөн жилдээ ажилд орсон нь цар тахал, эмнэлгийн ажилтны ажлын байрны эрэлттэй шууд холбоотой гэж үзсэн байна.
- Суулийн 5 жилийн хугацаанд сувилахуйн бакалаврын хөтөлбөрөөр 204, сувилахуйн дипломын 184 төгсөгчдөөс 85.2 % нь эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн ажил эрхэлж байна.
- Ажил эрхлээгүй 20 төгсөгчдийн 8 буюу 40% нь үргэжлүүлэн суралцах, 12 буюу 60% нь жирэмсэн ба бага насны хүүхдээ асарч байна.
- Эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж буй байдлын нийцлийг илрүүлэхэд сувилагч мэргэжлийн хувьд төгсөгчдийн ажил эрхлэлтийн одоогийн байдлаар 86.9% нь албан байгууллагад үндсэн эсвэл гэрээт ажил эрхэлж байна. 2022 оны байдлаар ажил эрхлэлт 86.9 % , 2019 онд 84.6 % байсан бөгөөд ажил эрхлэлт 3.0% иар өссөн байна.
- Ажлын байраар хангагдах хүртлээ зарцуулсан хугацааны хувьд тайлант хугацаанд 0.13 сар болж багассан үзүүлэлтэй байгаа нь эмнэлгийн ажиллагчдын ажлын байрны эрэлттэй шууд холбоотой байна.
- Төгсөгчдийн амьдарч буй байршлаар нь үзэхэд Улаанбаатар хотод 22.8 % , Дархан-Уул аймагт 27.6%, Сэлэнгэ аймагт 8.9%, Орхон аймагт 8.1% ажиллаж амьдарч байна. 2022 оныг 2019 ондоо харьцуулахад амьдарч буй байршлын хувьд сум орон нутагт амьдарч байгаа төгсөгчдийн эзлэх хувь нь 3.2 хувиар өссөн байна.
- Хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч үр дүнг хэрэгжүүлсэн байна.
- 2018 онд суралцагчид, төгсөгчид, ажил олгогчдын “Боловсролын үйлчилгээ- Сэтгэл ханамж” хэлэлцүүлгийг анх зохион байгуулсан бол 2021 оны 3 дугаар сарын 17-нд хэлэлцүүлгийг 2 дахь удаагаа зохион байгуулж санал зөвлөмжийг боловсруулсан байна.

Онцлог зүйл:

- Дархан анагаах төгсөгчдийн холбоо нь 2017 оны 11 сарын 24 ны өдрийн Монгол Улсын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй гишүүдэд үйлчилдэг төрийн бус байгууллагын чиглэл нь төгсөгчдийн судалгааг гарган ажиллах, төгсөгчдийн салбар хороодыг үе шаттайгаар байгуулах, төгсөгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалтыг зохион байгуулах, төгсөгчид болон сургуулийн харилцаа холбоог бэхжүүлэх, гишүүд харилцан туршлага мэдээлэл, туршлага солилцох чиг үүрэгтэй.
- Сайхан сэтгэл уулзалтыг зохион байгуулж “Сайхан сэтгэл” төгсөгчдийн түүхэн цуврал номыг гаргадаг. Жнь: 1979, 1989, 1999, 2009, 2019 оны төгсөгчдийн түүхэн ном.
- “Сайн санаа-Сайхан сэтгэл” сэтгүүлтэй
- “Төгсөгчдийн бичиг баримт” гэсэн сан үүсгэн хадгалдаг.

Дүгнэлт: Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллах боловсон хүчин бэлтгэгдэж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- 1969 онд 2 багштай, 50 оюутантай Сувилагчийн техник мэргэжлийн сургууль нэртэйгээр анх үүсгэн байгуулагдсан ба үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн эрдэм шинжилгээ, боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх мэдлэг, ур чадвар эзэмшсэн 11000 гаруй мэргэжилтэн бэлтгэн гаргасан бөгөөд 5469 төгсөгчийг сувилагч мэргэжлээр бэлтгэсэн байна.
- Мөн сургалтын тэргүүлэх чиглэл болох сувилахуйн хөтөлбөрийн шинэчлэлтийг олон улс болон үндэсний жишгийн дагуу тогтмол сайжруулж Ази Номхон далайн баруун бүсийн Анагаах Ухааны 100 шилдэг сургуулийн нэг болох эрхэм зорилгын хүрээнд Чанарын менежментийн тогтолцооны олон улсын ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэн, 2001, 2007, 2018 онуудад байгууллагыг магадлан итгэмжлүүлж, дэлхийн жишигт нийцсэн чадварлаг сувилагч мэргэжилтнийг бэлтгэх уриатай ажиллаж байна.
- Үндэсний хэмжээнд анх “Уламжлалт анагаах ухааны сувилагч” (СО91701) хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, БМИҮЗ-ийн Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын “Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг батламжлах тухай” 2022 оны 75 тоот тогтоолоор хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурыг бүрэн хангаж, 5 жилийн хугацаатай амжилттай магадлан итгэмжлүүлж, сургалтын үйл ажиллагааг эрхэлж байна.
- Дотоод гадаадын дараагийн шатны хөтөлбөрт амжилттай үргэлжлүүлэн суралцаж буй ШИЛДЭГ төгсөгчдийг алдаршуулан “Сайн санаа-сайхан сэтгэл” сэтгүүлийн Дархан анагаахын бахархал буланд хэвлэн нийтэлж сувилахуйн тусламж үйлчилгээний орчин үеийн чиг хандлага, эрдэм судлалын талаар мэдээллийг олон нийтэд нээлттэй байдлаар цахим хэлбэрээр байршуулдаг байна.
- Дархан –Уул аймаг дахь АУС-ийн бахархал болсон төгсөгчид Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан ШУГТЭ-ийн ЧХХМЗТ-ийн ахлах сувилагч, 1973 оны төгсөгч Ө.Тунгалаг, БНСУ-ын Ионсэй их сургуулийн докторант сувилахуйн мэргэжлийн төгсөгч Д.Дуламсүрэн, Нийгмийн эрүүл мэндийн магистр, Япон улсын Сувилахуйн сургуулийн докторант сувилахуйн мэргэжлээр төгсөгч Г.Ганцэцэг нар нь суралцагчдын бахархал болж байна.

Дүгнэлт: Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийгдсэн, дэлхийн түвшний сувилагч бэлдэх уриатай ажиллаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгч лэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	✓			
2	Сургалтын үйл ажиллагаа	✓			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	✓			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	✓			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	✓			
6	Багшийн үйл ажиллагаа	✓			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	✓			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Сургуулийн нэр	АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль
Хөтөлбөрийн нэр	Сувилахуй
Хөтөлбөрийн индекс	091301 бакалавр
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> • Сувилахуйн тусламж үйлчилгээг эмнэлгээс гарч буй өвчтөнд үзүүлж чадаж байгаа эсэхийг судалж үнэлэх
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • УМС-ийн тусламжтай суралцагч тухай улиралд судлах хичээл, заах багш, хичээлд хамрагдах өдөр, хичээллэх цагаа сонгон суралцах боломж бүрдсэн ч хөтөлбөрөөр элсэгчдийн тооноос хамаараад багшийг сонгох боломж хангалтгүй байгаад дүгнэлт хийж ажиллах
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> • Оюутны чөлөөт цагаа өнгөрөөх, хамт хичээл хийх боломжийг бүрдүүлэх , интернэт орчинг нэмэгдүүлэх • Сувилгааны түүх цахимаар хөтлөх чадварт суралцуулах, E-health программыг сургалтын үйл ажиллагаандаа нэвтрүүлэх • Ур чавдарын өрөөний бэлэн байдлыг сайжруулах, хичээлийн хэрэглэгдэхүүнийг хичээлийн агуулгаар нь байршуулах • Гадаадад эрдмийн зэрэг хамгаалсан судлаач сувилагч нарын бүтээлийг номын сандаа байршуулах
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • Төгсөгчдийг хөтөлбөрийн шинэчлэлд оролцуулах • Санхүүгийн олон эх үүсвэрийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах • Хөтөлбөрийн сурталчилгаа идэвхжүүлэлтийн хүртэмж, үр нөлөөг тодорхой болгох
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Оюутанд зориулсан үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар оюутнуудаас судалгаа авч, сайжруулдаг байх • Элсэн орсон суралцагчдаас хэдэн хувь нь төгсөж байгаад мониторинг хийж, шилжилт хөдөлгөөний шалтгааныг илрүүлэн, үр дүнг үйл ажиллагаандаа тусгах
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Багш нарын судалгаа шинжилгээний ажлын үр дүнгээс хөтөлбөрийн сайжруулалтад тусгах • Багш нарын нийгмийн асуудлыг дэмжих бодит ажлуудыг тогтмолжуулах

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн Сувилахуй бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэндийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг /С.Сэргэлэнчимэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Ц.Амаржаргал/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Ц.Оюундарь/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Г.Шүрэнмягмар/

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

Багш нар

№	Овог	Нэр	Албан тушаал	Заадаг хичээл	Мэргэжил	Эрдмийн зэрэг цол	Ажилласан жил
1	Лувсандаш	Оюун-Эрдэнэ	Тэнхимийн эрхлэгч	Гэрээр сувилахуй	Сувилахуй	БС-ын магистр	25
2	Гүрбазар	Ууганцэцэг	Ахлах багш	Мэдрэл, сэтгэцийн өвчний сувилахуй	Их эмч	АУ-ны магистр	19
3	Нацаг	Баярмаа	Ахлах багш	Мэргэжлийн англи хэл	Англи хэлний багш	Хэл шинжлэлийн магистр	26
4	Дагиймаа	Алтайхүү	Ахлах багш	Монголын түүх, соёл, ёс заншил, Хүний хөгжил, эрх зүй	Их эмч	Дэд профессор багш, Боловсрол судлалын доктор	30
5	Халзан	Амаржаргал	Ахлах багш	Өрхийн сувилахуй	Сувилахуй	СУ-ны магистр	40
6	Дамба	Оюунцэцэг	Ахлах багш	Сувилахуйн ур чадвар, Сувилгааны үйл ажиллагаа	Сувилахуй	БС-ын магистр	28
7	Гүрбазар	Намжилмаа	Ахлах багш	Сувилахуйн удирдлага, манлайлал	Сувилахуй	СУ-ын магистр	28
8	Лувсандорж	Отгонтөгс	Ахлах багш	Сувилахуйн удирдлага, манлайлал	Сувилахуй	БС-ын магистр	33
9	Мягмар	Нарантуяа	Ахлах багш	Арьсны өвчний сувилахуй	Их эмч	БС-ийн магистр	15
10	Ядамжав	Билэгмаа	Багш	Сэргээн засах	Сувилахуй	БС-ын магистр	23
11	Диваа	Отгонцэрэн	багш	Сувилахуйн үндэс	Сувилахуй	БС-ын магистр	20
12	Хадбаатар	Мөнхчулуун	Багш	Эхийн сувилахуй	Эх баригч, бага эмч	БС-ын магистр	13

1 3	Лхүндэв	Ганчимэг	Дадлагж игч багш	Эмгэг физиологи	Их эмч	БС-ын магистр	13
--------	---------	----------	---------------------	--------------------	--------	------------------	----

Төгсөгчдийн төлөөлөл

№	Төгсөгчийн овог нэр	Төгссөн он	Албан тушаал	Байгууллага
1.	Алтанх	2018	сувилагч	Амин холбоо өрхийн эрүүл мэндийн төв
2.	С.Наранцэцэг	2007	сувилагч	Дархан НЭ сэргээн засах тасаг
3.	С.Нэмэхбаяр	1995	сувилагч	Дархан НЭ сэргээн засах тасаг
4.	Ж.Итгэлтуяа	2007	сувилагч	Дархан НЭ сэргээн засах тасаг
5.	В.Цэцэгдарь	2006	сувилагч	Дархан НЭ сэргээн засах тасаг
6.	М.Ариунтуул	2012	сувилагч	Дархан НЭ сэргээн засах тасаг
7.	М.Нандин-Эрдэнэ	2016	Сувилахуйн арга зүйч	Дархан НЭ сэргээн засах тасаг
8.	Ч.Солонго	2002	сувилагч	ДНЭ Хагалгааны нэгдсэн тасаг
9.	Т.Өлзийсайхан	2004	сувилагч	ДНЭ Хагалгааны нэгдсэн тасаг
10.	Ж.Энхтунгалаг	2004	сувилагч	ДНЭ Хагалгааны нэгдсэн тасаг
11.	Б.Пүрэвсүрэн	2004	сувилагч	ДНЭ Хагалгааны нэгдсэн тасаг
12.	О.Отгонсүрэн	2003	сувилагч	ДНЭ Хагалгааны нэгдсэн тасаг
13.	Н.Энхтуул	1995	сувилагч	ДНЭ Хагалгааны нэгдсэн тасаг
14.	Б.Цэрмаа	2017	сувилагч	ДНЭ Хагалгааны нэгдсэн тасаг
15.	Р.Минжбадгар	1987	сувилагч	ДНЭ Мэдрэлийн тасаг
16.	С.Бямбасүрэн	2015	сувилагч	ДНЭ Мэдрэлийн тасаг
17.	Х.Оюунбилэг	2013	сувилагч	ДНЭ Мэдрэлийн тасаг
18.	Н.Хулан	2022	сувилагч	ДНЭ Мэдрэлийн тасаг
19.	Г.Бямбажаргал	2022	сувилагч	ДНЭ Мэдрэлийн тасаг
20.	Т.Баасанжаргал	2016	сувилагч	ДНЭ Мэдрэлийн тасаг
21.	Г.Энхээ	2020	сувилагч	Да НЭ Хүүхэд
22.	П.Мөнхцэцэг	1996	сувилагч	ДаНЭ Хүлээн авах
23.	Э.Энхбаяр	2007	сувилагч	ДаНЭ Хүлээн авах

24.	Б.Мөнхцэцэг	2004	сувилагч	ДаНЭ Хүлээн авах
25.	Б.Алтанцэцэг	2022	сувилагч	ДаНЭ Хүлээн авах
26.	Д.Чимэддулам	2011	сувилагч	ДаНЭ Хүлээн авах
27.	О.Эрдэнэчимэг	1997	сувилагч	ДаНЭ Хүлээн авах

Оюутны төлөөлөл

№	Оюутны овог нэр	Дамжаа	Утасны дугаар	Мэйл хаяг
1	Б.Нямцэцэг	Сувилахуй -1	95743050	nud22d066@st.mnums.edu.mn
2	Н.Батчимэг	Сувилахуй -1	94711644	NUD22D019@st.mnums.edu.mn
3	Ц.Хонгорзул	Сувилахуй -1	86630913	NUD22D018@st.mnums.edu.mn
4	Б.Даваадулам	Сувилахуй -1	95251034	NUD22C014@st.mnums.edu.mn
5	Г.Болоржин	Сувилахуй -1	80720042	Nud22d065@st.mnums.edu.mn
6	Гэрэлтуяа	Сувилахуй -1	99881255	NUD22D025@st.mnums.edu.mn
7	Н.Аззаяа	Сувилахуй -1	99372075	Nud22d011@st.mnums.edu.mn
8	Бат-оргил	Сувилахуй -1	86143432	NUD22D053@st.mnums.edu.mn
9	Т..Отгонцэцэг	Сувилахуй -1	94682806	NUD22D046@st.mnums.edu.mn
10	С.Нямбадам	Сувилахуй -1	85624797	NUD22D044@st.mnums.edu.mn
11	С.Дагиймаа	Сувилахуй -1	96694944	nud22d064@st.mnums.edu.mn
12	Г.Намуунаа	Сувилахуй -1	99026953	NUD21D004@st.mnums.edu.mn
13	Б.Хонгорзул	Сувилахуй -1	95511070	NUD22D039@st.mnums.edu.mn
14	Ариунтуяа	Сувилагч-3	99982842	NU20C023@st.mnums.edu.mn
15	Цэнгэл	Сувилагч-3	99297001	NU20C003@st.mnums.edu.mn
16	Хишигдаваа	Сувилагч-3	99344758	NU19C047@st.mnums.edu.mn
17	Эрдэнэбилэг	Сувилагч-3	99004507	NU20C062@st.mnums.edu.mn
18	Н.Болормаа	Сувилагч-3	99322815	NU20C063@st.mnums.edu.mn
19	Болортунгалаг	Сувилагч-3	95510211	Nu20c012@st.mnums.edu.mn

20	Хонгорзул	Сувилагч-3	99841175	NU20C093@st.mnums.edu.mn
21	Эрдэнэцэцэг	Сувилагч-3	99786416	NU20C113@st.mnums.edu.mn
22	Даваажаргал	Сувилагч-1	99371740	NUD22C030@st.mnums.edu.mn
23	Намуун	Сувилагч-1	99542877	NUD22C012@st.mnums.edu.mn
24	Отгончимэг	Сувилагч-1	85818082	NUD22C034@st.mnums.edu.mn
25	Номинтуяа	Сувилагч-1	99332856	NUD22C025@st.mnums.edu.mn
26	Б.Хувьзаяа	CA3-2	85170707	PMD21D008@st.mnums.edu.mn
27	Б.Номин	CA3-2	99446951	NUD21D009@st.mnums.edu.mn
28	Г.Маралгуа	Сувилагч-2	89921020	PMD21D037@st.mnums.edu.mn
29	Ч.Намуун	CA3-2	85393282	PMD21D077@st.mnums.edu.mn
30	Б.Оюунэрдэнэ	CA3-1	99392553	NUD21D006@st.mnums.edu.mn
31	Ц.Нямзагар	Сувилагч-2	86830060	NUD21D042@st.mnums.edu.mn
32	Н.Баярмаа	Сувилагч-2	85247976	NUD21C040@st.mnums.edu.mn
33	Т.Ууганцэцэг	Сувилагч-2	99650858	PMD21D068@st.mnums.edu.mn
34	Б.Минжин	CA3-2	95059124	PMD21D018@st.mnums.edu.mn
35	Даваадулам	CA3-1	95251034	NUD22D052@st.mnums.edu.mn

Ажил олгогчдын төлөөлөл

№	Овог нэр	Албан тушаал	Байгууллага
1	Б. Мөнхбат	Ерөнхий эмч	Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг
2	А. Оюун-Эрдэнэ	Сувилахуйн албаны дарга	Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг
3	О.Хишигсүрэн	Сувилахуй хариуцсан мэргэжилтэн	Дархан-Уул аймгийн ЭМГ
4	Ц.Эрдэнэчимэг	Ерөнхий эмч	Сэлэнгэ аймгийн НЭ
5	Б. Мөнхцацрал	Сувилахуйн албаны дарга	Сэлэнгэ аймгийн НЭ
6	Б.Амгалан		Архангай Нэгдсэн эмнэлэг дарга

7	З.Алтантовч	Сувилахуйн албаны дарга	Архангай Нэгдсэн эмнэлэг
8	Г.Дашжанцан	Ерөнхий эмч	Өвөрхангай БОЭТ
9	Б.Тунсагбямба	Сувилахуйн албаны дарга	Өвөрхангай БОЭТ
10	С.Энхцэцэг	Сувилахуй хариуцсан мэргэжилтэн	Өвөрхангай ЭМГ
11	Б.Эрдэнэцэцэг	Сургалтын албаны дарга	Орхон БОЭТ
12	Л.Эрдэнэчимэг	Сувилахуйн албаны дарга	Орхон БОЭТ
13	Д.Отгонсүрэн	Сувилахуй хариуцсан мэргэжилтэн	Булган аймгийн ЭМГ
14	Түмэнжаргал	Хүний нөөцийн менежер	Булган аймаг НЭ
15	А.Энхжаргал	Сувилахуйн албаны дарга	Хөвсгөл аймаг НЭ
16	А.Даваажаргал	Сувилахуйн албаны арга зүйч	Хөвсгөл аймаг НЭ
17	Ц.Баянхишиг	Сувилахуйн албаны арга зүйч	Баянхонгор аймаг НЭ
18	Нацагсүрэн	Сувилахуйн албаны дарга	УБ Нэгдсэн хоёрдугаар эмнэлэг
19	Болорхорлоо	Сувилахуйн албаны дарга	ЭХЭМҮТ
20	Ю.Нямхүү	ЭЭ, Мэдээгүйжүүлэг тасгийн ахлах сувилагч	ЭХЭМҮТ
21	Оюун-Эрдэнэ	Сувилахуй хариуцсан мэргэжилтэн	НЭМГ
22	Г.Нямгэрэл	Сувилахуйн албаны дарга	УБ ЧДНЭ
23	Энхтуяа	Сувилахуйн албаны дарга, ХНМ	УБ Энэрэл эмнэлэг
24	Б.Халиунгэрэл	Сувилахуйн албаны дарга	УБ ХУДНЭ
25	Б.Мөнхчимэг	Сувилахуйн албаны арга зүйч	УБ БГДНЭ
26	Д.Урангоо	Хүний нөөцийн менежер	УБ БГДНЭ
27	Д.Отгон	Ахлах сувилагч	УББЗД 9 хороо ӨЭМТ
28	Б.Амаржаргал	Ахлах сувилагч	Амин холбоо
29	Мөнхнцэцэг	Сувилахуйн мэргэжилтэн	Сэлэнгэ ЭМГ
30	Н.Баасанжаргал	Сувилахуйн арга зүйч	Улсын гуравдугаар эмнэлэг
31	М. Лхагвамаа	Сувилахуйн арга зүйч	Улсын гуравдугаар эмнэлэг
32	Түмэнжаргал	Сувилахуйн албаны арга зүйч	Улсын дөрөвдүгээр эмнэлэг
33	Б.Сандагаа	ЭЭ, Хөнгөвчлөх тасгийн ахлах сувилагч	Улсын дөрөвдүгээр эмнэлэг

34	Д.Оюунчимэг	Сувилахуйн албаны дарга	СХДЭМТ
35	Б. Нарангэрэл	Сувилахуй эрхэлсэн орлогч дарга	Багануур ЭМТ
36	Н.Цэрэнлхам	Сувилахуйн албаны дарга	Налайх ЭМТ
37	Б.Нармандах	Сувилахуйн албаны дарга	НТТТ
38	Г.Мандах	Сувилахуйн албаны дарга	СЗКЭ
39	А.Амарцэнгэл	Сувилахуйн албаны дарга	СБЭМТ
40	О.Хишигжаргал	Сувилахуйн албаны арга зүйч	СБЭМТ

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



АШУУИС
1942

**АШУУИС-ИЙН ДАРХАН-УУЛ
АЙМАГ САЛБАР
АНАГААХ УХААНЫ СУРГУУЛЬ**

13 дугаар баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45051
Утас: 70377734

Цэжиг нууцад: darhanuul@mnuu.edu.mn
2023.08.30 № 197
танай _____-ны № _____-Т

Боловсролын Магадлан
Итгэмжлэх Үндэсний Зөвлөлд

Хүсэлт гаргах тухай

Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн ажлын албаны захирлын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/159 тоот тушаалаар томилогдсон шинжээчийн баг тус сургууль дээр 2023 оны 06 дугаар сарын 10-11-ны өдрүүдэд ажиллаж "Сувилахуй" 091301 бакалавр, дипломын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан, шалгуурын дагуу илрэл, нотлох баримттай танилцаж хөндлөнгийн үнэлгээ хийсэн болно. Шинжээчийн багийн хөндлөнгийн үнэлгээний тайланг 2023 оны 08 дугаар сарын 29-ны өдөр хүлээн авч хөндлөнгийн үнэлгээ хийсэн тухай шинжээчийн тайлантай танилцсан. Шинжээчдийн хөндлөнгийн тайланг бид хүлээн зөвшөөрч байна.

ЗАХИРАЛ → Б.БАЯСГАЛАНМӨНХ

